Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

# ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ | ТӨСӨВ | ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ | СУУРЬ ТҮВШИН | ЗОРИЛТОТ ТҮВШИН | ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ /ХҮРЭЭГҮЙ БОЛ ТАЙЛБАР/ | ХУВЬ |
|---|---|---|---|---|---|---|---|
| **НЭГ. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1 | **Зорилт 1.1** Иргэдэд зориулсан спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХ 2.2.3/ | - | Ажлын явц, хувь | - | Спортын цогцолборын зураг төсөл хийлгэнэ. | Газрын асуудал шийдэгдэж байна. | 50% |
| 2 | 1.1.1 Спортын цогцолборын барилгын зураг төсөл, төсвийг хийлгэн, барилга угсралтад шаардагдах хөрөнгийг улс, нийслэлийн төсөвт тусгуулахаар уламжилна. | 200.0 /ДТХО/ | Ажлын явц, хувь | - | Спортын цогцолборын зураг төсвийг хийлгэн, дээд шатны байгууллагад санхүүжилтийг шийдвэрлүүлэх ээр санал | Спортын цогцолборын эскиз зургийг 2020 онд "Дуншагайн хас" ХХК-аар гүйцэтгүүлсэн. Байршлыг 8 дугаар хороонд төлөвлөж, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/891 дүгээр захирамжаар 24836 м2 газар "Спорт цогцолбор"-ын зориулалтаар олгогдож, №000012805 дугаар газар эзэмших эрхийн гэрчилгээ гаргуулсан. Гэвч тус газарт "Спорт цогцолбор"-ын барилгаас гадна "Цэцэрлэг", | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | уламжилсан байна. | “Дүүргийн төрийн албан хаагчдын орон сууц” барихаар шийдвэрлэсэн тул, газар эзэмших гэрчилгээний зориулалтыг “Спортын цогцолбор, цэцэрлэг, үйлчилгээтэй орон сууц” болгон өөрчлүүлэхээр Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүсэлт хүргүүлсэн. Газрын зориулалт өөрчлүүлэхээр хүлээгдэж байна. | |
| 3 | **Зорилт 1.2** Цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын түвшинг үе шаттайгаар өсгөнө. /ЗГҮАХ 2.3.9.2/ | - | Ажлын явц, хувь | - | 3-аас доошгүй цэцэрлэгийн барилгыг эхлүүлнэ. | 3 цэцэрлэгийн газрын асуудал шийдвэрлэгдсэн. | 50% |
| 4 | 1.2.1 Шинээр 3-аас доошгүй цэцэрлэгийн барилгын ажлыг эхлүүлнэ. | 3,000.0 /ДТХО/ | Барилгын ажлыг эхлүүлсэн цэцэрлэгийн тоо | - | 3-аас доошгүй цэцэрлэгийн барилгын ажлыг эхлүүлсэн байна. | Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2021 онд Яармаг, Нисэх, Төвийн бүсэд 200 ор бүхий тус бүр 1, 1 цэцэрлэгийн барилга барихаар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр тогтоолоор баталсан.<br><br>Тус цэцэрлэгүүдийн байршлын судалгааг Хан-Уул дүүргийн Газар зохион байгуулалтын албатай хамтран хийж, Яармагийн бүсийн цэцэрлэгийг Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1081 дүгээр захирамжаар нийслэлийн Боловсролын газарт олгогдсон 5000 м2 газарт барихаар Хот байгуулалт, хөгжлийн газраас архитектур төлөвлөлтийн даалгаврыг хүссэн. Нисэхийн бүсийн цэцэрлэгийг Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/398 дугаар захирамжаар газар эзэмших эрх нь хүчингүй болж, дүүргийн Засаг даргын 2021 оны А/281 дүгээр захирамжаар цэцэрлэгийн барилгын зориулалтаар олгогдсон “Буянт-Ухаа-1” хорооллын зүүн талын 3000 м2 газарт барихаар Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд газар эзэмших эрхийг | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Нийслэлийн Засаг даргын захирамжаар баталгаажуулахаар албан бичиг хүргүүлсэн.<br>Төвийн бүсийн цэцэрлэгийг Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/394 дүгээр захирамжаар газар эзэмших эрх нь хүчингүй болж, дүүргийн Засаг даргын 2021 оны А/296 дугаар захирамжаар цэцэрлэгийн барилгын зориулалтаар олгогдсон "Рапид харш" хорооллын баруун хойд талын 3700м2 газарт барихаар Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд газар эзэмших эрхийг Нийслэлийн Засаг даргын захирамжаар баталгаажуулахаар албан бичиг хүргүүлсэн. | |
| 5 | **Зорилт 1.3** Гэр хорооллын өрхүүдийн ундны усны эх үүсвэрийг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХ 3.7.11/ | - | Ажлын явц, хувь | - | 25% /3-аас доошгүй худгийн барилга ашиглалтад орсон байна./ | Худгуудын газрын асуудлыг шийдвэрлэж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. | 50% |
| 6 | 1.3.1 Гэр хорооллын шаардлагатай байршлуудад 3-аас доошгүй ундны усны худгийг ашиглалтад оруулна. | 240.0 /ДТХО/, 60.0 /ДОНХС | Ашиглалтад орсон худгийн тоо | - | 3-аас доошгүй байршилд гүний худаг ашиглалтад оруулсан байна. | Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020-2021 онд он дамжин хэрэгжиж буй 12, 13 дугаар хороонд гүний худаг байгуулах ажлын зураг төсвийг "Зэндмэнэтулга" ХХК-аар гүйцэтгүүлэн, тендер зарлуулсан. Гүйцэтгэгчээр "Грандхолдинг" ХХК шалгарсан, гэрээ байгуулагдаж байна. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2021 онд 9, 11, 12, 13, 14 дүгээр хороодод баригдах гүний худгийн тендер зарлагдсан. 2 байгууллага тендер ирүүлсэн бөгөөд үнэлгээ хийгдэж байна. | 50% |
| 7 | **Зорилт 1.4** Хороолол дундах зам талбайн ус зайлуулах сувгууд болон үерийн далан хамгаалалтыг шинээр бий болгоно. /ЗГҮАХ 3.7.12/ | - | Ажлын явц, хувь | - | 25% /2 байршилд үерийн ус зайлуулах шугам татсан байна./ | 2 байршилд үерийн ус зайлуулах шугамын ажил хийгдэж байна. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | 1.4.1 Дүүргийн 9 дүгээр хороонд тохижилт, үерийн хамгаалалт хийх ажлыг дуусган, ашиглалтад оруулж 6,7 дугаар хороонд голын гадаргын ус зайлуулах шугам татах ажлыг хийнэ. | 85.0 /ДТХО/ | Ажлын явц, хувь | Гэрээ байгуулагдсан | Ажлуудыг дуусган, ашиглалтад оруулсан байна. | Дүүргийн 9 дүгээр хороонд тохижилт, үерийн хамгаалалт хийх ажлыг "СБМ" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна. Сагсан бөмбөгийн талбайн цутгалт хийгдэж, хашаа, тоног төхөөрөмжүүд суурилуулагдсан.Ус зайлуулах сувгийн ажил хийгдэж байна. 6,7 дугаар хороонд голын гадаргын ус зайлуулах шугам татах ажлыг "Юу би жи" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд материал татан авалт хийгдсэн. Ажил хийгдэх бэлтгэл ажил хангагдаж байна. Дундаж хувь – 70%. | 90% |
| 9 | **Зорилт 1.5** Нийтийн эзэмшлийн зам талбайн камержуулалтыг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХ 4.3.2/ | - | Ажлын явц, хувь | - | 50% /250-аас доошгүй байршилд камержуулсан байна./ | Камержуулалтын ажлуудын байршлын судалгааг хийж, техникийн нөхцөл, техникийн даалгаврыг батлуулсан. Худалдан авах ажиллагааны шатанд байна. | 50% |
| 10 | 1.5.1 Дүүргийн 1-11, 13-21 дүгээр хороодын нутаг дэвсгэрт 250-аас доошгүй камер суурилуулж, хуучирч муудсан камеруудыг сэргээн засварлана. | 1,319.9 /ДОНХС/ | Ажлын явц, хувь | - | Нийтийн эзэмшлийн талбайд 250-аас доошгүй камер суурилуулна. | Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020-2021 онд он дамжин хэрэгжих 591.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий "Камержуулалт"-ын ажил шууд гэрээ байгуулах шатанд байна.<br>2021 онд шинээр хэрэгжих 730.49 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий "Камержуулалт"-ын ажлын техникийн тодорхойлолтыг гаргуулахаар Нийслэлийн Мэдээлэл, технологийн газарт Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 06/54 дүгээр албан бичгийг хүргүүлсэн.<br>Ковид-19 халдварт өвчний улмаас Нийслэлийн Мэдээлэл, технологийн газарт даалгавар батлах ажил удааширч 2021 оны 06 дугаар сарын 03-ны Кам/А2906032021 дугаартай техникийн нөхцөл, техникийн тодорхойлолтыг батлуулан тендер зарлуулахаар Худалдан авах ажиллагааны албанд хүргүүлсэн. Тендер зарлагдах шатанд байна. | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | **Зорилт 1.6** Замын хөдөлгөөний нягтралыг сарниулж, ачааллыг тэнцвэржүүлсэн, авто замыг шинээр байгуулна. /ЗГҮАХ6.1.6/ | - | Ажлын явц, хувь | - | 50% /Хатуу хучилттай авто замыг байгуулсан байна./ | 5, 16, 21 дүгээр хороодод 3.2 км хатуу хучилттай авто зам тавих ажил 40%-тай хийгдэж байна. | 70% |
| 12 | 1.6.1 Дүүргийн авто замын ачааллыг тэнцвэржүүлэх, зорчих хэсгийг сайжруулах зорилгоор 4 км-ээс доошгүй хатуу хучилттай авто замыг ашиглалтад оруулна. | 3,305.4 /ДТХО/, НТХО | Ашиглалтад орсон хатуу хучилттай авто зам, км | Ажлын явц 20 хувьтай | 4 км-ээс доошгүй хатуу хучилттай авто зам тавигдсан байна. | Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2020-2021 онд хэрэгжих "Хатуу хучилттай авто зам тавих" ажлыг гүйцэтгүүлэхээр "Хомын тал" ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Тус ажлын хүрээнд 5, 16, 21-р хороодод 3.2 км авто зам тавигдах бөгөөд ажлын явц дараах байдалтай байна. Үүнд:<br>1. 5-р хороо Яармагийн замын цахилгаан, дулаан, холбооны ажил, авто замын хашлага болон газар шорооны ажил хийгдэж байна.<br>2. 16-р хороо Дулаан шугам хүчилтгэх ажил, хөрс хуулалтын ажил хийгдэж байна.<br>3. 21-р хороо хөрс хуулалт, ухмалын ажил бүрэн хийгдсэн, хашлага хийгдэж байна.<br>Нийслэлийн төсвийн хөрөнгөөр дүүргийн 11 дүгээр хороо, "Ривер хиллс" хотхоноос Зайсангийн гудамж хүртэлх 1 км"-ийн хатуу хучилттай зам Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулах шатандаа байна. | 70% |
| 13 | **Зорилт 1.7** Явган хүний болон унадаг дугуйн зам, авто машины зогсоол, хүүхдийн тоглоомын талбай барьж байгуулан, тоосжилтыг бууруулна. /ЗГҮАХ 6.1.7/ | - | Ажлын явц, хувь | - | Тохижилтын ажлыг хийж, тоосжилтыг тодорхой хувиар бууруулсан байна. | 7.2 км явган хүний зам тавих ажил 80%-тай хийгдэж байна. 2 байршилд авто зогсоол байгуулах, 21 байршилд тохижилт, тоглоомын талбай байгуулах ажил худалдан авах ажиллагааны шатанд байна. | 63.3% |
| 14 | 1.7.1 Иргэдийн аюулгүй зорчих нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор явган хүний | 184.0 /ДТХО/ | Ажлын явц, хувь | Ажлын явц 60 хувьтай. | 7200 км-ээс доошгүй явган хүний зам ашиглалтад орсон байна. | Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2020-2021 онд он дамжин хэрэгжиж буй "Явган хүний зам барих" ажлыг "Морин сувд" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд 2, 3, 9, 11, 12, 14, 15, 20 дугаар | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зам тавих ажлыг дуусган, ашиглалтад оруулна. | | | | | | хороодод 7.2 км явган хүний зам барих ажил 80%-тай хийгдэж байна. | |
| 15 | 1.7.2 2-оос доошгүй байршилд авто зогсоол шинээр байгуулна. | /ДТХО/ | Авто зогсоолын тоо | - | 2-оос доошгүй байршилд авто зогсоол байгуулагдсан байна. | | Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2020-2021 онд он дамжин хэрэгжих "Орчны тохижилт"-ын ажлын хүрээнд 20-р хороо 43-р байрны гадна авто зогсоол бүхий бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулагдах бөгөөд 2021.05.11-нд тендер зарлагдаж, 2021.06.11-нд нээлт хийсэн. Нээлт хийхэд 3 компани тендер ирүүлсэн бөгөөд үнэлгээ хийгдэж байна. 2021 онд шинээр хэрэгжих "Орчны тохижилт"-ын ажлын хүрээнд 10-р хороо Автомашины зогсоол байгуулах /60/1 дүгээр байрны хойд талбайд/ ажлын зураг төсвийг "Нью товер" ХХК-аар гүйцэтгүүлэн, ажлын зураг төсвийг тендер зарлуулахаар Худалдан авах ажиллагааны албанд хүргүүлсэн. Тендер зарлагдах шатанд байна. | 50% |
| 16 | 1.7.3 Нийтийн эзэмшлийн зам талбайд орчны тохижилтын ажлыг гүйцэтгэнэ. | 1,120.0 /ДТХО/ | Тохижилт хийсэн талбайн тоо | - | 8-аас доошгүй байршилд тохижилтын ажил хийгдсэн байна. | | Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2020-2021 онд он дамжин хэрэгжих "Орчны тохижилт"-ын ажлын хүрээнд 7 байршилд тохижилтын ажил хийгдэх бөгөөд 2021.05.11-нд тендер зарлагдаж, 2021.06.11-нд нээлт хийсэн. Нээлт хийхэд 3 компани тендер ирүүлсэн бөгөөд үнэлгээ хийгдэж байна. 2021 онд шинээр хэрэгжих "Орчны тохижилт"-ын ажлын хүрээнд 10 байршилд тохижилтын ажил хийгдэх бөгөөд ажлын даалгавар, зураг төсвийг батлуулан тендер зарлуулахаар Худалдан авах ажиллагааны албанд хүргүүлсэн. Тендер зарлагдах шатанд байна.<br>Мөн нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих эрх шилжиж ирсэн тохижилт, хүүхдийн тоглоомын талбай байгуулах 4 төсөл, арга хэмжээний ажлын даалгаврыг батлуулан, тендер зарлуулсан. 2021.06.28-нд нээлт хийнэ. | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | **Зорилт 1.8** Туул, Дунд голын дагуух дүүргийн нутаг дэвсгэрт амралт, үйлчилгээний эко зурвасуудыг байгуулна. /ЗГҮАХ6.1.8/ | - | Ажлын явц, хувь | - | Эко зурвасыг Яармагийн гүүр хүртэл үргэлжлүүлэн тавьсан байна. | Худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гэрээ байгуулах зөвлөмжийг Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн. | 50% |
| 18 | 1.8.1 Зайсангийн гүүрнээс Яармагийн гүүр хүртэл Туул голын эрэг дагуу дугуйн замтай "ЭКО" зурвас байгуулах ажлыг үргэлжлүүлнэ. | 600.0 /ДТХО/ | Ажлын явц, хувь | 2020 онд 1.6 км эко зурвас байгуулсан | Яармагийн гүүр хүртэл 1,4 км эко зурвас байгуулсан байна. | 2020 онд дүүргийн төсвийн хөрөнгөөр 19 дүгээр хороонд Туул голын эрэг дагуу хийгдсэн явган хүний болон дугуйн зам, амралтын талбай бүхий эко зурвасыг 2021 онд Мишээл экспогоос Яармагийн гүүр хүртэл үргэлжлүүлэн хийхээр батлуулсан. Тус ажлын даалгаврыг батлуулан, 2021.04.26-нд тендер зарлагдсан. 2021.05.26-нд нээлт хийж "Наранбосголт" ХХК-ийг шалгаруулан, гэрээ байгуулах зөвлөмжийг Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн. | 50% |
| 19 | **Зорилт 1.9** Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх, ил тод байдлыг сайжруулах, олон нийт оролцох, мэдээлэл хүргэх дэвшилтэт арга хэлбэрийг нэвтрүүлнэ. /ЗГҮАХ 6.2.6/ | - | Санал асуулга зохион байгуулсан эсэх | - | Жил бүр санал асуулга зохион байгуулсан байна. | Санал асуулгыг цахим хэлбэрээр явуулсан. | 100% |
| 20 | 1.9.1 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд иргэдээс авах санал асуулгыг цахим аппликейшн ашиглан зохион байгуулна. | ҮА-ны зардлаар | Цахим санал асуулга зохион байгуулсан эсэх | - | Цахим санал асуулга зохион байгуулсан байна. | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх ажилд иргэдээс авах санал асуулгыг 2021.03.01-04.01-ний өдрийн хооронд SMART UB аппликейшныг ашиглан цахим хэлбэрээр явуулсан. Цахим санал асуулгад хамрагдах боломжтой 90308 иргэн байгаа гэж тооцоолсноос 56923 иргэн санал өгч, нийт иргэдийн 63%-ийн ирцтэй санал асуулга явагдаж дууссан. Саналын дүнг нэгтгэх ажил хийгдэж байна. | 100% |
| 21 | **Зорилт 1.10** Гэр хорооллын айл өрхүүдийг стандартын | - | Агаарын бохирдлыг | 2018-2020 онд агаарын | 2021-2024 онд агаарын | Гэр хорооллын айл өрхүүдийг түлшээр хангах 60 борлуулалтын цэг, 3 хангамжийн баазын түлш татан авалт, түгээлтэд тогтмол хяналт | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шаардлага хангасан түлшээр хангаж, агаарын бохирдлыг бууруулна. /ЗГҮАХ 5.1.1/ | | бууруулсан хувь | бохирдлыг 50% бууруулсан . | бохирдлыг 80% бууруулна. | тавьж дүүрэг, нийслэлийн Онцгой комиссыг мэдээллээр хангаж ажилласан. 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 14-ний өдөр хүртэл хугацаанд 28590.4 тн түлшээр гэр хорооллын айл өрхүүдийг хангасан.<br>2021 оны 8 дугаар сараас эхлэн өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд түлш нөөцлөх, татан авах, борлуулалтын цэгүүдийн бэлтгэл хангуулах ажлууд хийгдэнэ. | |
| 22 | 1.10.1 Гэр хорооллын айл өрхүүдийг стандартын шаардлага хангасан түлшээр хангах борлуулалтын цэг, хангамжийн баазуудыг байгуулж, хэвийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллана. | - | Хангамжийн бааз, борлуулалтын цэг, тоо | 3 хангамжийн бааз, 57 борлуулалтын цэг байгуулсан . | 3 хангамжийн бааз, 50-аас доошгүй борлуулалтын цэг байгуулна. | Гэр хорооллын айл өрхүүдийг түлшээр хангах 60 борлуулалтын цэг, 3 хангамжийн баазын түлш татан авалт, түгээлтэд тогтмол хяналт тавьж дүүрэг, нийслэлийн Онцгой комиссыг мэдээллээр хангаж ажилласан. 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 14-ний өдөр хүртэл хугацаанд 28590.4 тн түлшээр гэр хорооллын айл өрхүүдийг хангасан. | 70% |
| 23 | 1.10.2 Агаарын бохирдлын эх үүсвэр, хор уршиг, дэвшилтэт техник, технологи, ногоон амьдралын хэв маягийн талаар танин мэдүүлэх, зөв дадал хэвшүүлэх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Цэвэр агаар – Цэлмэг тэнгэр” арга хэмжээг бүсчлэн зохион байгуулна. | 5000.0 /ЗДТГ/ | Зохион байгуулсан арга хэмжээ, тоо | 1 арга хэмжээ зохион байгуулсан . | 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулна. | Коронавирусын халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Цэвэр агаар – Цэлмэг тэнгэр” арга хэмжээг хойшлуулж, 9, 10 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөсөн.<br>2021 оны 1, 2, 3, 4 дүгээр сард гэр хороолол бүхий хороодын нутаг дэвсгэрт түүхий нүүрсийг хориглох, сайжруулсан шахмал түлшний нийлүүлэлт, хэрэглээнд болон хог хаягдал, орчны бохирдолд хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус 525 хүнийг ажиллуулсан. Орон тооны бус гэрээт ажилчид, “Таван толгой түлш” ХХК-ийн хяналтын ажилчидтай хамтарч гэр хорооллын айл өрхүүдэд угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зөвлөмж, зөв галлагаа, угаарын хийн мэдрэгчийг ажиллуулах заавар бүхий 30000 ширхэг зөвлөмж, сэрэмжлүүлгийг тараасан. Мөн дүүрэг, хорооны цахим хуудсаар дамжуулан угаарын хийн хордлогоос | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | урьдчилан сэргийлэх, зөв галлагааны зөвлөмж, сэрэмжлүүлгийг тогтмол хүргэж ажилласан. | |
| 24 | 1.10.3 Дүүргийн хэмжээнд агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогыг зохион байгуулж, цахим бүртгэлийн санд оруулна. | - | Цахим мэдээллийн сан, тоо | - | Тооллогын арга хэмжээ зохион байгуулсан байна. | Нийслэлийн Засаг даргын 2020 оны "Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл хийх ажлын хэсэг байгуулах тухай" А/1286, дүүргийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 25-ны А/31 дүгээр захирамжийн дагуу агаарын чанарыг сайжруулах 2 дугаар бүс буюу сайжруулсан түлш түлэх 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16, 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрийн хэмжээнд 2020 оны агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн бүртгэл, тооллогыг батлагдсан журмын дагуу явуулж, "Орчны бохирдлын эх үүсвэр, хаягдлын тооллогын мэдээллийн сан" цахим мэдээллийн системд бүртгэх ажлыг 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 02 дугаар сарын 25-ны өдөр хүртэл хугацаанд зохион байгуулсан.<br>Дүүргийн хэмжээнд "Орчны бохирдлын эх үүсвэр, хаягдлын тооллогын мэдээллийн сан" цахим мэдээллийн системд ердийн галлагаатай 3-15 кВт хүчин чадалтай 12552 зуух бүртгэгдсэнээс сууцны төрлөөр нь авч үзвэл 42.4 хувь буюу 5319 нь гэрт, 57.6 хувь буюу 7233 нь байшинд ашиглагдаж байна.<br>Мөн нийт бүртгэгдсэн ердийн галлагаатай 3-15 кВт хүчин чадалтай 12552 зуух хэрэглэгч өрхийн 39.1 хувь буюу 4906 нь сайжруулсан, 60.9 хувь буюу 7646 нь ердийн зуух ашиглаж байна. | 100% |
| 25 | **Зорилт 1.11** Гэр хорооллын айл өрхүүдэд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг нэвтрүүлж, хөрсний | Улсын төсөв | Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тоо | 350 ариун цэврийн байгууламж нэвтрүүлсэн. | Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг 700-д хүргэнэ | Улсын төсвийн 1.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Туул голын сав дагуух 1000 өрхөд стандартын шаардлага хангасан нүхэн жорлон нэвтрүүлэх ажил хийгдсэн. | 85% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бохирдлыг бууруулна. /ЗГҮАХ 5.1.4/ | | | | | | |
| 26 | 1.11.1 Гэр хорооллын айл өрхүүдэд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг нэвтрүүлж, хөрсний бохирдлыг бууруулна. | Улсын төсөв | Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тоо | 350 ариун цэврийн байгууламж нэвтрүүлсэн. | Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг 700-д хүргэнэ | Улсын төсвийн 1.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Туул голын сав дагуух 1000 өрхөд стандартын шаардлага хангасан нүхэн жорлон нэвтрүүлэх ажил хийгдэж байгаа бөгөөд 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 850 өрхийн хашаанд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг суурилуулж, хөрсний бохирдлыг бууруулсан.<br>Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай 485 өрхийн судалгааг гаргаж Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлсэн. | 85% |
| 27 | **Зорилт 1.12** " Ковид-19" халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ. /ЗГҮАХ 1.1/ | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, Хэрэгжилтийн хувь | - | 16-аас дээш арга хэмжээ зохион байгуулна. | “Ковид-19” цар тахлын үед нийт 6 төрлийн судалгааг тогтмол гаргаж УОК, ДОК болон Шуурхай штаб, холбогдох дээд шатны байгууллагад тухай бүр хүргүүлэн, мэдээллээр хангаж ажилласан. | 50% |
| 28 | 1.12.1 “Ковид-19” халдварт цар тахлын үед дүүргийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллага болон тусгаарлан ажиглах байраар ашиглах боломжтой объектын судалгаа, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн судалгааг тогтмол гаргаж, хянана. | - | Судалгааны тоо, Хэрэгжилтийн хувь | - | 4-өөс дээш удаа судалгаа гаргаж, баяжилт хийнэ. | 1. Хан-Уул дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй эмийн сангийн судалгааг 2, 4 дугээр саруудад гаргасан. Судалгаагаар дүүргийн хэмжээнд нийт 135 эмийн сан үйл ажиллагаа явуулж байна.<br>2. Хан-Уул дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй оргүй хувийн эмнэлгүүдийн судалгаа гаргасан. Судалгаагаар нийт 64 эмнэлэгт эмч-662, сувилагч-402, бусад ажилчид-743 байна.<br>3. Хан-Уул дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй хувийн ортой эмнэлгүүдийн судалгааг гаргасан. Судалгаагаар 12 эмнэлэг, нийт | 50% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэвтэн эмчлүүлэх орны тоо-830, Их эмч-170, сувилагч-301 байна.<br>4. Хан-Уул дүүргийн Улсын эмнэлгүүдийн судалгааг гаргасан. Судалгаагаар нийт 3 эмнэлэгт Эмч-219, сувилагч-193, асрагч-51, бусад ажилчид-223 байна.<br>5. Эм, эмнэлгийн хэрэгсэл, нэг удаагийн хувцас, ариутгалын бодисын нөөцийн судалгааг тогтмол гаргаж, хяналт тавьсан. Коронавирусын халдвар /Ковид-19/-ын үед сайн дурын ажилтан бэлтгэх сургалтад хамрагдах иргэдийн судалгаа, Нөхцөл байдал хүндэрсэн үед сайн дураараа ажиллах хувийн эмнэлгүүдийн эмч, эмнэлгийн ажилтны судалгааг тус тус гаргасан. | |
| 29 | **Зорилт 1.13** "Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, орон нутагт хийгдэх оношилгоо, эмчилгээнд алсын технологи ашиглан, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ. /ЗГҮАХ 2.1.6/ | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, Хэрэгжилтийн хувь | - | 4-өөс дээш арга хэмжээ зохион байгуулна. | "Эрүүл дүүрэг" дэд хөтөлбөрийн 5.1.3-т "Иргэдэд эмчийн шаардлагатай зөвлөгөө, мэдээллийг өгөх зорилгоор "Цахим эмч" төслийг хэрэгжүүлж, цахимаар эмчилгээ, зөвлөмжийг хүргэх ажлыг хэрэгжүүлнэ" заалтыг тусгасан. | 10% |
| 30 | 1.13.1 "Цахим эмч" апплэйкэшин нэвтрүүлж иргэд өөрсдөө чихрийн шижин, цусны даралт зэрэг зонхилон тохиолдох өвчнийг өдөр тутам хянах бөгөөд 24 цагийн онлайн зөвлөгөө авах боломжтой болгоно. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | Холбогдох цахим үйлчилгээг нэвтрүүлж, хэвшүүлнэ. | "Эрүүл дүүрэг" дэд хөтөлбөрөөс санхүүжилт хүссэн "Цахим эмч" төслийг Эрүүл мэндийн төвтэй хамтран боловсруулсан бөгөөд төслийг дэд хөтөлбөрийн Салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэсэн. | 10% |
| 31 | **Зорилт 1.14** "Эрүүл чийрэг эр хүн" арга хэмжээг хэрэгжүүлнэ. /ЗГҮАХ 2.1.1.7/ | - | Зохион байгуулсан арга хэмжээний | - | 4-өөс дээш арга хэмжээ зохион байгуулна. | "Эрүүл дүүрэг" дэд хөтөлбөрт дүүргийн Эрүүл мэндийн төвд "Эрэгтэйчүүдийн кабинет" байгуулж, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн | 10% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тоо, Хэрэгжилтийн хувь | | | боловсролыг дээшлүүлэх, үзлэг оношилгоонд хамруулах заалтыг тусган батлуулсан. | |
| 32 | 1.14.1 Дүүргийн Эрүүл мэндийн төвд эрэгтэйчүүдийн кабинет байгуулна. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | Кабинет байгуулж, үйл ажиллагаар хэвшүүлнэ. | Дэд хөтөлбөрөөс санхүүжилт хүссэн төслийг Эрүүл мэндийн төвтэй хамтран боловсруулсан бөгөөд хөтөлбөрийн Салбар зөвлөлийн хурлаар уг төслийг хэлэлцүүлэхээр бэлтгэсэн.<br>Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг 2021 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөнд дүүргийн "Эрүүл мэндийн төвд эрэгтэйчүүдийн кабинет байгуулах" саналыг хүргүүлсэн. | 10% |
| 33 | **Зорилт 1.15** Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлнэ. /ЗГҮАХ 2.2.1/ | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, Хэрэгжилтийн хувь | - | 16-аас дээш арга хэмжээ зохион байгуулна. | "Эрүүл дүүрэг" дэд хөтөлбөрийн 5.1.6-д "Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, иргэдийг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор тэдний насны онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн оюуны болон биеийн тамир спортын олон талт арга хэмжээг дэмжиж ажиллана" заалтыг тусган батлуулсан. | 50% |
| 34 | 1.15.1 "Иргэдийн спортын наадам" 8 төрөлт спортын тэмцээн зохион байгуулж, дараагийн шатны тэмцээнд бэлтгэнэ. | 55,0 сая-ДТХО | Спортын төрлийн тоо, Хамрагдсан иргэдийн тоо, Хэрэгжилтийн хувь | Спортын 7 төрөлд 1500 иргэнийг хамруулсан. | 4-өөс доошгүй спортын төрөлд 1000 иргэн хамруулна. | 1. Цар тахлын үед идэвхтэй хөдөлгөөн хийх, биеийн дархлааг дэмжих зорилготой "Эрүүл мэндийн цахим гүйлт-2021" арга хэмжээг Биеийн тамир, спорт хороотой хамтран зохион байгуулсан. Тус арга хэмжээнд Хан-Уул дүүргийн 1343 иргэн хамрагдаж нийт 16417 км зам гүйсэн амжилтаар нийслэлийн бүсэд 3-р байрт шалгарсан.<br>2. Ерөнхий боловсролын сургуулиудын биеийн тамир, спортын талбайг стандартын | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дагуу тохижуулах, аж ахуйн нэгжид олгосон газрыг сургуулийн эзэмшил газарт буцаан олгох ажлын хүрээнд дүүргийн төрийн өмчийн 18 сургуулийн спорт талбайг газар дээр нь очиж судлан, нэгдсэн дүн мэдээг холбогдох газарт хүргүүлсэн.<br>Коронавирусийн халдвар, /Ковид-19/ цар тахлын улмаас Монгол Улсын Засгийн газрын тогтоол, улс, нийслэл, дүүргийн Онцгой комиссын шийдвэрийн дагуу олон нийтийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулахыг хориглосон тул Иргэдийн спортын наадмыг зохион байгуулаагүй. | |
| 35 | **Зорилт 1.16** Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж, махны экспортын хэмжээг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХ 3.3.3/ | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2 арга хэмжээ | Иргэдийн хүнсний хангамжийг нэмэгдсэн байна. | Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 2 арга хэмжээ зохион байгуулж, 293 тн мах худалдан борлуулах ажлыг зохион байгуулж ажилласан. | 100% |
| 36 | 1.16.1 Иргэдийн хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор мах, хүнсний ногоог хэрэглэгчдэд шууд нийлүүлэх ажлыг зохион байгуулна. | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2 арга хэмжээ зохион байгуулж, 512 тн хүнсний ногоо, 385 тн мах худалдан борлуулах ажлыг зохион байгуулсан | Иргэдийн хүнсний хангамжийг нэмэгдсэн байна | Дүүргийн хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор нөөцийн махны худалдааг 34 дэлгүүрээр 120 тн мах, 2021 оны 05, 06 дугаар сарын амралтын өдрүүдэд өргөтгөсөн худалдааг 10 удаа, давхардсан тоогоор 25 байршилд 173,9 тн махыг тус тус худалдаалах ажлыг зохион байгуулж, дүүрэг дэх Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын хэлтэс, хороодтой хамтран халдвар хамгааллын дэглэм, махны чанар аюулгүй байдалд хяналт тавьж ажилласан. Нийт 293.9 тонн нөөцийн мах худалдан борлуулах ажлыг зохион байгуулж, махны хангамжийг нэмэгдүүлж ажилласан. | 100% |
| 37 | **Зорилт 1.17** Жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдэд орчин үеийн санхүүжилтийн | - | Зохион байгуулсан арга | 2 арга хэмжээ | Үйлдвэрлэл эрхлэгчийн тоо нэмэгдсэн байна. | Яармаг ОНӨААТҮГ-т байрлах "Хан-Уулд үйлдвэрлэв" борлуулалтын төвд 36 үйлдвэрлэл эрхлэгчийн бараа бүтээгдэхүүнийг борлуулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэлбэрүүдийг нэвтрүүлж, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг төрөөс бизнес инкубацын үйлчилгээгээр бойжуулж, томруулах бодлого хэрэгжүүлнэ. /ЗГҮАХ 3.3.13/ | | хэмжээний тоо | | | | |
| 38 | 1.17.1 "Хан-Уулд үйлдвэрлэв" борлуулалтын нэгдсэн төвийн үйл ажиллагааг өргөжүүлэн, үйлдвэрлэл эрхлэгчдийн үйлдвэрлэл, борлуулалтыг дэмжиж ажиллана. | - | Дэмжин ажилласан үйлдвэрлэл эрхлэгчийн тоо | 20 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан. | Дотоодын үйлдвэрлэл нэмэгдсэн байна | Яармаг ОНӨААТҮГ-т байрлах "Хан-Уулд үйлдвэрлэв" борлуулалтын төвд 36 үйлдвэрлэл эрхлэгчийн бараа бүтээгдэхүүнийг борлуулан ажилласан. 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн цар тахлын нөхцөл байдлын улмаас үйл ажиллагааг нь түр хугацаагаар зогсоосон. Цаашид "Хан-Уулд үйлдвэрлэв" борлуулалтын төвийг хүн амын нягтаршил сайн, ашигтай талбай руу нүүлгэн шилжүүлэх ажлыг дүүргийн Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвтэй хамтран судалж, танилцуулга бэлтгэн Нийслэлийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих газарт хүргүүлсэн. | 100% |
| **ХОЁР. ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 39 | **Зорилт 2.1.** Төрийн байгууллага, албан тушаалтныг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттай зохион байгуулж, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, шуурхай, нээлттэй байдлыг хангана. /ҮХ 2.1/ | - | Зохион байгуулсан сургалт, хамрагдсан албан хаагчдын тоо | 3 удаагийн сургалтад 280 албан хаагч хамруулсан. | Төлөвлөгөөт сургалт 2-оос доошгүй, 100 хүртэлх албан хаагчийг хамруулна. | Төрийн байгууллага, албан тушаалтныг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлын хэрэгжилтийг хангуулж байна. | 30% |
| 40 | 2.1.1 Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, иргэд, албан хаагчдыг авилгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр | - | Зохион байгуулсан сургалт, хамрагдсан албан хаагчдын тоо | 3 удаагийн сургалтад 280 албан хаагч хамруулсан. | Төлөвлөгөөт сургалт 2-оос доошгүй, 100 хүртэлх албан хаагчийг хамруулна. | Дүүргийн авлигын эсрэг үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөг 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдөр батлуулж, дүүргийн www.khanuul.mn цахим хуудасны ил тод буланд байршуулсан. Төлөвлөгөөнд 6 чиглэлийн 15 арга хэмжээг хэрэгжүүлэн | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сургалт зохион байгуулж, соён гэгээрүүлэх ухуулга сурталчилгааг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | | | | | ажиллахаар төлөвлөсөн. Коронавируст /Ковид-19/ цар тахалтай холбоотойгоор төлөвлөгөөт сургалтууд 2021 оны 3, 4-р улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн. | |
| 41 | **Зорилт 2.2** "Хүнсний ногоо" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, өрхийн тариалан эрхлэгч болон хүнсний ногооны төрөлжсөн аж ахуйн нэгж, хоршоог дэмжих замаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. /ҮХ 1/ | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2 арга хэмжээ | Хүнсний ногооны үйлдвэрлэл нэмэгдсэн байна. | Хүнсний ногооны тариалалтыг дэмжих ажлын хүрээнд хүнсний ногоо, хүлэмжийн таримлын үр хөнгөлөлттэй авах ногоочдын хүсэлтийн дагуу 4 аж ахуйн нэгж 167 иргэнд хүнсний ногооны үрийг хөнгөлөлттэй үнээр олгож, тариалалтыг дэмжин ажилласан. | 50% |
| 42 | 2.2.1 Хөрс, цаг уурын онцлогт тохирсон хүнсний ногооны үр олгож, өрхийн тариалан эрхлэгчдийг дэмжиж ажиллана. | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2 арга хэмжээ зохион байгуулж, хүнсний ногооны үрийг 150 өрхөд олгосон. | Өрхийн тариалалт нэмэгдсэн байна. | Хүнсний ногооны тариалалтыг дэмжих ажлын хүрээнд хүнсний ногоо, хүлэмжийн таримлын үр хөнгөлөлттэй авах ногоочдын хүсэлтийн дагуу бөөрөнхий сонгино 0,5 тн, шар луувангийн үр 5 кг, шар манжин 1 кг, хүрэн манжин 2 кг, урт сонгино 15 кг, сармис 40 кг, буурцай 2 кг, тарвас 0,1 кг, хүлэмжийн хэмх 300ш, чинжүү 1 кг үрийг 4 аж ахуйн нэгж 167 иргэнд хөнгөлөлттэй үнээр олгож, тариалалтыг дэмжин ажилласан. | 50% |
| 43 | **Зорилт 2.3** "Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж, хоол тэжээлийн талаарх хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлнэ./ҮХ 2/ | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | Хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлсэн байна. | Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын үед сургууль цэцэрлэгийн үйл ажиллагаа хязгаарласантай холбогдуулан хэрэгжих хугацаа хойшилсон. | -% |
| 44 | 2.3.1 Хүүхдийн насны онцлогт тохирсон "Эрүүл хооллолт" сургалтыг ЕБС, цэцэрлэгийн эрхлэгч, тогооч нарт зохион байгуулна. | - | Сургалтад хамрагдсан байгууллагын тоо | - | Сургууль,цэцэрлэгийн 50 гаруй ажилтныг хамруулж, чадваржуулна. | Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын үед сургууль цэцэрлэгийн үйл ажиллагаа хязгаарласантай холбогдуулан хэрэгжих хугацаа хойшилсон. | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 45 | **Зорилт 2.4** "Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж иргэд, төрийн албан хаагчдын жендерийн ойлголт, хандлагыг нэмэгдүүлнэ. /ҮХ 1/ | - | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо, хамрагдсан иргэний тоо, хэрэгжилтийн хувь | 115 арга хэмжээнд 18656 иргэн хамруулсан. | 30-аас доошгүй үйл ажиллагаа зохион байгуулж 3000 иргэнийг хамруулна. | Хан-Уул дүүргийн "Жендерийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр"-ийн төслийг боловсруулж Жендерийн салбар хорооны гишүүдэд танилцуулсан бөгөөд дүүргийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангасан. | 50% |
| 46 | 2.4.1 Жендерийн эрх тэгш байдлыг хангах дүүргийн дэд хөтөлбөрийг боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | - | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо, хамрагдсан иргэний тоо, хэрэгжилтийн хувь | 3 аян, 6 сургалтад 18826 иргэн хамруулсан. | 10-аас доошгүй үйл ажиллагаа зохион байгуулж 500 иргэнийг хамруулна. | 1. Жендерийн хэвшмэл ойлголтыг бууруулах зорилгоор "Би жендерийн хэвшмэл ойлголтын эсрэг байна" аяныг 2021 оны 03 дугаар сард хороодод өрнүүлж, цахим мэдээллийн сувгаар иргэдэд хүргэсэн. Аяны хүрээнд ЖҮХ-оос 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулсан "Монгол эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүтэй байдлын суурь судалгааны зарим тодорхой асуудал" цахим хэлэлцүүлэгт дүүргийн Жендерийн асуудал хариуцсан мэргэжилтэн болон 21 хорооны Хөгжлийн нийгмийн ажилтнууд оролцсон.<br>"Жендерийн үндэсний сургагч багш бэлтгэх" сургалтыг 2021 оны 05 дугаар сард зохион байгуулж, НХХ-ийн дарга, 9 дүгээр хорооны Хөгжлийн нийгмийн ажилтан Л.Дэлгэрмаа нар оролцож сургагч багш болсон. | 50% |
| 47 | **Зорилт 2.5** "Эрүүл шүд-Эрүүл хүүхэд үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох, амны хөндийн өвчлөлийг эрүүлжүүлэх, бууруулах арга хэмжээг зохион байгуулна. /ҮХ 2/ | - | Үйл ажиллагааны тоо, Үзлэгт хамруулж эрүүлжсэн хүүхдийн хувь | Үзлэгт 16248 хүүхэд хамруулж, 46% нь эрүүлжсэн. | Үзлэгт 30000 хүүхэд хамруулж 50% эрүүлжүүлнэ. | Амны хөндийн үзлэгт 3742 хүнээс 935 буюу 25% нь хүүхдийн үзлэг байсан бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 12%-р өссөн байна. | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 48 | 2.5.1 СӨББ болон ЕБС-ийн хүүхдүүдэд амны хөндийн эрүүл ахуйн боловсрол олгох сургалт, үзлэг зохион байгуулна. | - | Үйл ажиллагааны тоо, Үзлэгт хамруулж эрүүлжсэн хүүхдийн хувь | Үзлэгт 7034 хүүхэд хамруулж, 3657 буюу 52% нь эрүүлжсэн. | 8 арга хэмжээ зохион байгуулж, үзлэгт хамрагдсан хүүхдийн 20% эрүүлжүүлнэ. | Амны хөндийн үзлэгт анхдагчаар 935 хүүхэд хамрагдснаас 657 хүүхэд буюу 32% нь эрүүлжүүлсэн байна. Энэ нь урд оноос 2.1%-иар өссөн үзүүлэлттэй байна.<br>Мөн Эрүүл мэндийн төвийн Шүдний кабинетад ирж эмчилгээ хийлгэсэн 215 хүүхдэд видео болон биечлэн муляж дээрх сургалтыг хийж, амны хөндийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг олгосон.<br>Дэлхий нийтээр тархаад буй коронавирусийн халдварын тохиолдол Монгол Улсад ихэсч байгаатай холбогдуулан Монгол Улсын Засгийн газар, улс, нийслэл, дүүргийн Онцгой комиссын шийдвэрээр бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагааг түр зогсоосон тул сургууль, цэцэрлэг дээр үзлэг, сургалтыг зохион байгуулаагүй. | 50% |
| **ГУРАВ. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 49 | **Зорилт 3.1** Хүүхдийн зуслан, бичил цэцэрлэгт хүрээлэнгийн тоог нэмэгдүүлж, иргэдийн эрүүл аюулгүй хөгжлийн орчныг бүрдүүлэх бодлого баримтална. /НЗДҮАХ 5.1.1.1/ | - | Ажлын явц, хувь | - | 25% /Ногоон байгууламж, бичил цэцэрлэгт хүрээлэн нэмэгдүүлсэн байна./ | Эко зуслангийн газрын гэрчилгээ гарсан. "Эко ахмадын сувилал ОНӨААТҮГ-ын гадна тохижилт, ногоон байгууламжийн ажлын гэрээ байгуулагдаж байна. | 50% |
| 50 | 3.1.1 Ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэнг нэмэгдүүлж, хүүхдийн зуслангийн газрын байршлын судалгаа хийж, зураг төсөл, төсвийг хийлгэнэ. | 100.0 /ДТХО/ | Ажлын явц, хувь | - | Эко зуслангийн зураг төсөл, төсвийг хийлгэж, ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ. | Өөрийн зуслангийн байргүй залуу гэр бүлүүдэд зориулсан "Эко зуслан"-г 14 дүгээр хороонд байгуулахаар төлөвлөн газрын гэрчилгээг гаргуулсан. Газрын байршлыг Нийслэлийн Засаг даргын Захирамжаар баталгаажуулах бэлтгэл ажил хийгдэж байна.<br>Мөн 2021 онд дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих "Эко ахмадын сувилал ОНӨААТҮГ-ын гадна талбайд тохижилт, ногоон байгууламж" хийх ажлын даалгаврыг батлуулан 2021.04.23-нд тендер зарлагдаж, | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2021.05.24-нд нээлт хийсэн. Гүйцэтгэгчээр “Ганхэлхээ констракшн” ХХК шалгарч, гэрээ байгуулагдах шатанд байна. | |
| 51 | **Зорилт 3.2** Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, орон сууц, гэр хорооллын гэрэлтүүлгийг сайжруулж, нэгдсэн удирдлагын системд бүрэн холбоно. /НЗДҮАХ 6.3.30/ | - | Ажлын явц, хувь | - | 50% /Нийтийн эзэмшлийн талбайн гэрэлтүүлэг нэмэгдсэн байна./ | Нийслэлийн төсвийн хөрөнгөөр дүүргийн 12 дугаар хороо Малчны хэсэгт 45 ширхэг гэрэлтүүлэг шинээр хийгдэж, ашиглалтад оруулсан.<br>Дүүргийн гэр хороолол болон орон сууцны гэрэлтүүлгийн сайжруулах ажлын хүрээнд говийн зам дагуух 48 натри гэрлийг 100вт лед гэрэл болгон шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. | 50% |
| 52 | 3.2.1. Хороодын нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, орон сууц, гэр хороололд 450-аас доошгүй гэрэлтүүлгийг шинээр суурилуулж, засвар, үйлчилгээг тогтмол хийж гүйцэтгэнэ. | 900.0 /ДТХО/ | Ажлын явц, хувь | - | Нийтийн эзэмшлийн талбайд 450-аас доошгүй гэрэлтүүлэг суурилуулсан байна. | Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2020-2021 онд хэрэгжиж буй “Гэрэлтүүлэг”-ийн ажлын гүйцэтгэгчээр “Хүрд” ХХК ажиллаж байна. Ажлын зураг, төсөв хийгдсэн, батлагдах шатанд байна.<br>Нийслэлийн төсвийн хөрөнгөөр дүүргийн 12 дугаар хороо Малчны хэсэгт 45 ширхэг гэрэлтүүлэг шинээр хийгдэж, ашиглалтад оруулсан. | 50% |
| 53 | **Зорилт 3.3** Гэр хорооллыг шинэ үзэл баримтлалын дагуу хөгжүүлж, иргэдэд боломжийн өртөгтэй орон сууцтай болох “Зөв шийдэлтэй” дахин төлөвлөлтийг системтэйгээр хийнэ. /НЗДҮАХ 6.1.7/ | - | Ажлын явц, хувь | - | 25% /Дахин төлөвлөлтөд холбогдох байгууллагад дэмжлэг үзүүлж ажиллана./ | Гэр хорооллыг дахин барилгажуулах ажлын хүрээнд 4 дүгээр хороонд “Андын зам Констракшн” ХХК 760 айлын 40 га газрыг дахин барилгажуулах төслийг хэрэгжүүлж, 3547 айлын орон сууцны хотхоныг 2025 онд бүрэн ашиглалтад оруулахаар ажиллаж байна. | 70% |
| 54 | 3.3.1 Гэр хорооллын иргэдэд дахин төлөвлөлтийн талаар сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулж, иргэдийн хүсэлтийг холбогдох байгууллагуудад | ҮА-ны зардлаар | Сургалт, үйл ажиллагаа-ны хэрэгжилтийн явц, хувь | - | Сургалт, уулзалт зохион байгуулсан байна. | Гэр хорооллыг дахин барилгажуулах ажлын хүрээнд 4 дүгээр хороонд “Андын зам Констракшн” ХХК 760 айлын 40 га газрыг дахин барилгажуулах төслийг хэрэгжүүлж, 3547 айлын орон сууцны хотхоныг 2025 онд бүрэн ашиглалтад оруулахаар ажиллаж байна. | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | уламжлан хамтран ажиллана. | | | | | Ковид 19 цар тахлын улмаас сургалт, уулзалт зохион байгуулаагүй. | |
| 55 | **Зорилт 3.4** Ашиглалтын шаардлага хангахгүй байгаа нийтийн зориулалттай орон сууцуудыг үе шаттайгаар шинэчилнэ. /НЗДҮАХ 6.1.9/ | - | Ажлын явц, хувь | - | Дахин төлөвлөлтөд холбогдох байгууллагад дэмжлэг үзүүлж ажиллана. | 1, 2, 3, 10, 13, 16, 19, 20-р хороодод нийтийн зориулалттай орон сууцны засвар, тохижилтын ажлууд худалдан авах ажиллагааны шатанд байна. | 50% |
| 56 | 3.4.1 Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны оршин суугч иргэдэд дахин төлөвлөлтийн чиглэлээр сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулна. | ҮА-ны зардлаар | Сургалт, үйл ажиллагааны хэрэгжилтийн явц, хувь | - | Сургалт, уулзалт зохион байгуулсан байна. | 10 дугаар хорооны АШХНЗОС 34, 35 дугаар байрнуудын үнэлгээг өнөөгийн ханшаар дахин үнэлэх дүүргийн Засаг даргын захирамж гарсан.<br>10 дугаар хорооны АШХНЗОС 34, 35, 11-р хорооны Сүрьеэгийн 20, 12-р хорооны 39-р байрнуудын дахин төлөвлөлтийн ажлыг Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх саналыг НЗДТГ-т хүргүүлсэн.<br>Ковид 19 цар тахлын улмаас сургалт, уулзалт зохион байгуулаагүй. | 50% |
| 57 | 3.4 2 Нийтийн зориулалттай болон хуучин орон сууц, түүний шугам сүлжээний засвар тохижилтын ажлыг хийж гүйцэтгэнэ. | 1170.0 /ДТХО/ | Засварын ажлын явц, хувь | - | 5-аас доошгүй нийтийн зориулалттай орон сууцны засвар, тохижилтын ажил хийгдсэн байна. | Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2020-2021 онд он дамжин хэрэгжих "Нийтийн зориулалттай орон сууцны засвар, тохижилт"-ын ажлын хүрээнд 1, 2, 3, 10, 19, 20-р хороонд 14 орон сууцны 49 орцны засварын ажлыг гүйцэтгэх бөгөөд дахин тендер зарлах шатанд байна.<br>2021 онд шинээр хэрэгжих "Нийтийн зориулалттай орон сууцны засвар, 2, 19-р хороо" ажлын зураг төсвийг "Алтан дуулга" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд магадлалын дүгнэлт хүлээгдэж байна.Мөн "Нийтийн зориулалттай орон сууцны засвар, цахилгааны шугам татах, 10, 13, 16-р хороо" төсөл, арга хэмжээ тендер зарлагдах шатанд байна.<br>Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих "Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр засвар, 1, 2, 15, 17-р хороо/ ажлын байршлын судалгааг хийн, | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажлын даалгаврыг батлуулж, 2021.05.12-нд тендер зарлаж, 2021.06.14-нд нээлт хийсэн. 3 компаниас тендер ирүүлсэн, үнэлгээ хийгдэж байна. | |
| 58 | **Зорилт 3.5** Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулж ангилан ялгах ажлыг эрчимжүүлж, хүнсний хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулж органик бордоо үйлдвэрлэлтэд дэмжлэг үзүүлж ажиллана. /НЗДҮАХ 5.2.7/ | - | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ | - | Дүүргийн хэмжээнд хоол үйлдвэрлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудаас гарч буй хүнсний хог хаягдлыг ангилан ялгах ажлыг эхлүүлнэ. | Дүүргийн хэмжээнд хог хаягдлыг ангилан ялгаж хэвшсэн. | 30% |
| 59 | 3.5.1 Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулж ангилан ялгах ажлыг эрчимжүүлж, хүнсний хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах чиглэлээр хоол үйлдвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагад мэдлэг, мэдээлэл олгох сургалт зохион байгуулна. | - | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ | - | Дүүргийн хэмжээнд хоол үйлдвэрлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудаас гарч буй хүнсний хог хаягдлыг ангилан ялгах ажлыг эхлүүлнэ. | Дүүргийн хэмжээнд хог хаягдлыг ангилан ялгаж хэвшсэн 18 ЕБС сургууль, 29 цэцэрлэг, 79 СӨХ, 12 аж ахуйн нэгж байгууллагуудын ангилсан, дахивар хог хаягдлыг "Тохижилт үйлчилгээний төв" ОНӨААТҮГ-ын 2 авто машин, "Мог пластик" ХХК-ны 5 автомашинаар ангилсан хог хаягдлыг тогтмол хуваарийн дагуу ачиж тээвэрлэж байна.<br><br>Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Сууц өмчлөгчдийн дээд холбооноос зохион байгуулсан "Хогоо ангилж сурья" аянд Хан-Уул дүүргийн Сууц өмчлөгчдийн холбоод амжилттай оролцож 8 СӨХ шагналт байранд шалгарсан. Тэргүүн байранд дүүргийн 4 хорооны "Шинэ Өргөө" СӨХ шалгарч зохион байгуулагчдаас хог ангилан ялгах сав байршуулж дэмжлэг үзүүлсэн.<br><br>"Тохижилт үйлчилгээний төв" ОНӨААТҮГ нь хүнсний хог хаягдлыг ачиж тээвэрлэхэд зориулан 13-68 УББ, 13-94 УББ улсын дугаартай автомашинуудыг тоноглож бэлтгэн ажиллаж байна. Дүүргийн 1, 2, 3, 4, 20 дугаар | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хороодын хоол үйлдвэрлэгч нийт 45 аж ахуй нэгжээс 55 рейсээр 137,5 тонн хоолны, органик хог хаягдлыг ачиж тээвэрлэсэн. | |
| 60 | 3.5.2 Гэр хорооллын айл өрхүүдийг галлагаанаас гарсан үнсийг ангилан ялгах ажлыг эхлүүлнэ. | - | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ | - | Гэр хорооллын айл өрхийн үнсийг ангилаг ялгах, тусад нь тээвэрлэх ажлыг эхлүүлнэ. | Гэр хорооллын айл өрхүүдийг үнсийг тусад нь ангилан ялгах савтай болгох ажлыг 8 дугаар сараас эхлэн зохион байгуулахаар бэлтгэж байна. | 10% |
| 61 | **Зорилт 3.6** Хотын соёлыг төлөвшүүлж түгээн дэлгэрүүлэх ажлыг бүх шатанд зохион байгуулна. /НЗДҮАХ 2.6.3/ | - | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо, хамрагдсан иргэний тоо, хэрэгжилтийн хувь | 14 арга хэмжээнд 45992 иргэн хамруулсан. | 16 үйл ажиллагаа зохион байгуулж 60000 иргэнийг хамруулна. | "Залуучуудын хөгжил" дэд хөтөлбөрийн 5.3.2-т "Бүх шатны боловсролын байгууллага, соёлын болон төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран хүүхэд, залуучуудын дунд соёлын боловсрол олгох "Хотын соёл Хан-Уул дүүргээс" олон нийтийн аяныг зохион байгуулна" заалтыг тусган батлуулсан. | 30% |
| 120 | 4.20.1 Хорооноос үзүүлж буй төрийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | - | Цахимаар үзүүлэх үйлчилгээний нэр төрөл, үйлчилгээ үзүүлж байгаа хороодын тоо | Дүүргийн 1 хороонд 5 төрлийн төрийн үйлчилгээ үзүүлж байна. | 2-оос дээш хороонд цахим үйлчилгээг нэвтрүүлсэн байна. | Азийн сантай хамтран дүүргийн 7 дугаар хороонд Оюуны эмч, Улсын Бүртгэлийн газрын иргэний бүртгэлийн 4 төрлийн үйлчилгээ 2020 оноос эхлэн хэрэгжсэн бөгөөд үргэлжлүүлэн 1, 3, 5, 7, 9, 12, 18, 19 дүгээр хороодод 4 төрлийн үйлчилгээг үзүүлж эхэлсэн. 2021 оны эхний хагас жилийн байдлаар иргэний цахим үнэмлэхийн сунгалт 1392 иргэн, шинээр цахим үнэмлэх 576 иргэнд, цахим үнэмлэх дахин олголт 2017 иргэнд, нийт 3985 иргэнд төрийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэн ажиллаж байна. | 50% |
| 121 | **Зорилт 4.21** Төрийн албан хаагчдыг чадавхжуулах, мэргэшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж, албан хаагчдын чиг үүргийн давхардлыг арилгах, хэлтэс, албадын ажлын уялдаа холбоог сайжруулах ажлыг | - | Бүтэц орон тоог шинэчлэн баталсан эсэх, зохион байгуулсан сургалт, албан хаагчдын тоо | 16 удаагийн сургалтад 187 албан хаагчийг хамруулсан. | 15-аас доошгүй сургалтад 100-аас доошгүй албан хаагчийг хамруулна. | Төрийн албан хаагчдыг чадавхжуулах, мэргэшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулна. /ДЗДҮАХ 3.3.1/ | | | | | | |
| 122 | 4.21.1 Төрийн албаны тухай хууль болон холбогдон гарсан журмын хүрээнд бүтэц орон тоог шинэчлэн баталж, албан хаагчдыг сургаж хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулан, дотоод болон гадаадын богино, дунд хугацааны сургалтад хамруулж мэргэшүүлнэ. | - | Бүтэц орон тоог шинэчлэн баталсан эсэх, зохион байгуулсан сургалт, албан хаагчдын тоо | 16 удаагийн сургалтад 187 албан хаагчийг хамруулсан. | 15-аас доошгүй сургалтад 100-аас доошгүй албан хаагчийг хамруулна. | Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог дүүргийн Засаг даргын 2021 оны А/01 дүгээр захирамжаар шинэчлэн баталж, хэлтэс, албадын уялдаа холбоог сайжруулах ажлыг судлан албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/05 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн чиг үүрэг, ажлын байрны шинжилгээг зохион байгуулж, албан тушаалын харьцуулалтыг Нийслэл дэх Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлэн ажилласан. Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/44 дүгээр тушаалаар "Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг батлуулсан. Удирдлагын академийн мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 1 албан хаагч, "Албан хэрэг хөтлөлт", "Ёс зүй", "Excel програм", "Өргөдөл гомдлын системийн ашиглалт", "Худалдан авах ажиллагааны А3" зэрэг сургалтуудад давхардсан тоогоор 51 албан хаагчийг хамруулсан. | 50% |
| 123 | **Зорилт 4.22** Төрийн албан хаагчийн үйл ажиллагаа үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана. /ДЗДҮАХ 3.3.3/ | - | Төлөвлөгөө батлуулсан эсэх, үр дүн, тайлагналт | 12 заалтын хүрээнд төлөвлөгөө боловсруулан, тухай бүр хэрэгжилтийг тайлагнасан. | Сахилга хариуцлагатай, ёс зүйтэй төрийн албыг бүрдүүлсэн байна. | Засгийн газрын 2020 оны 217, 218 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах хүрээнд албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлж дүгнэх "Үнэлгээний баг"-ийн бүрэлдэхүүнийг ЗДТГ-ын даргын 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/65 дугаар тушаалаар батлуулан, Засаг даргын Тамгын газрын 10 хэлтэс, тасаг, албадын 67, хороодын 51 нийт 118 албан хаагчийн 2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тушаалын 7,8 дугаар хавсралтаар батлагдсан загвар, аргачлалын дагуу хүлээн авсан. Үүнээс албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах нийтлэг үүргээ хангалтгүй гүйцэтгэн, удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийг хангалтгүй биелүүлэн "Сануулах" сахилгын шийтгэл ногдуулсан 1 албан хаагч, шинээр томилогдсон 7, жирэмсний ээлжийн амралтаа авч орж ирсэн 2, нийт 10 албан хаагчид үр дүнгийн урамшууллыг олгоогүй. Бусад 108 албан хаагчдад Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн Б/173 дугаар тушаалаар урамшууллыг холбогдох журмын дагуу олгосон. | |
| 124 | 4.22.1 Засгийн газрын 258 дугаар тогтоолын хүрээнд төлөвлөгөө гарган батлуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллана. | - | Төлөвлөгөө батлуулсан эсэх, үр дүн, тайлагналт | 12 заалтын хүрээнд төлөвлөгөө боловсруулан, тухай бүр хэрэгжилтийг тайлагнасан. | Сахилга хариуцлагатай, ёс зүйтэй төрийн албыг бүрдүүлсэн байна. | Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг ханган ажиллаж, сахилга хариуцлага, дэг журмыг чангатган хяналт тавьж ажиллах талаар дүүргийн 21 хороод, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадад сахилга хариуцлага, дэг журмыг мөрдөн ажиллах зөвлөмж, мэдээг Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 04/615 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | 50% |
| 125 | **Зорилт 4.23** Дүүргийн хэмжээнд "Эко хүлэмж бүс" төсөл, хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. /ДЗДҮАХ 3.2.1/ | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | Хөдөө аж ахуйг дэмжих сангийн хүлэмжийн зээлэнд 6 иргэн хамрагдсан | Хүлэмжийн тариалалт нэмэгдсэн байна. | Дүүрэгт 2021-2024 онд хэрэгжих "Эко ногоон дүүрэг" дэд хөтөлбөрийн хүрээнд хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлэх чиглэлээр 2021 онд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулсан. | 30% |
| 126 | 4.23.1 Хүлэмжийн аж ахуй эрхлэх сонирхолтой иргэдэд хүлэмж барих заавар, хүлэмжийн | - | Сургалтын тоо, хамрагдсан иргэн, аж | - | Салбарын ажилтнуудын чадавх дээшилнэ. | Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран хөдөө аж ахуйн салбарт баримтлах бодлого, онолын суурь мэдлэг олгох онлайн хичээлийг зохион байгуулж, ногоочдын | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тариалалт, бүтээгдэхүүний боловсруулалт, маркетинг чиглэлээр цогц сургалт зохион байгуулж, хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлнэ. | | ахуйн нэгжийн тоо | | | сонирхсон асуудлуудад хариулт өгч ажилласан.<br>Дүүргийн хэмжээнд 2021 онд 167 га талбайд төмс, хүнсний ногоо, 20000м2 талбайд хүлэмжийн тариалалт хийх тооцоо судалгааг гаргаж ажилласан.<br>Дүүргийн ногоочдын тариалсан 520 тн хүнсний ногоонд гарал үүслийн гэрчилгээ олгосон.<br>Хөдөө аж ахуйн дэмжих сангаас хөнгөлөлттэй үнээр олгох хүлэмжийн зээлэнд 4 иргэнийг дэмжиж тодорхойлсон. | |
| 127 | **Зорилт 4.24** Дүүргийн байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ хэрэгжүүлнэ./ ДЗДҮАХ 3.4.1/ | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | Дотоодын аялал жуулчлал хөгжинө. | Цар тахлын улмаас хэрэгжих хугацаа хойшилсон. | - |
| 128 | 4.24.1 "Их түүхийн жимээр" аяллын маршрут гаргаж батлуулж, иргэдэд сурталчлан таниулна. | - | Маршрут гаргана | - | Дотоодын аялал жуулчлал хөгжинө. | Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах түүх соёлын хөшөө, дурсгалт 32 газрын зурагт танилцуулга бүхий судалгааг гаргаж, 20 зогсоол бүхий аяллын маршрутын төслийг боловсруулсан. | 20% |
| 129 | **Зорилт 4.25** Дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн дэргэдэх "Бойжуулах төв"-ийн үйл ажиллагааг өргөжүүлэн, үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээг нэмэгдүүлж, дэмжлэг үзүүлэх олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ. /ДЗДҮАХ 4.3.7/ | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 5 иргэний үйлдвэрлэлийг дэмжин ажилласан. | Үйлдвэрлэл эрхлэгчдийн борлуулалт нэмэгдсэн байна. | Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2 дугаар байрны 1 давхарт байрлах 2 өрөө 32м2 өрөөнд "Бойжуулах төв"-д 12 үйлдвэрлэл эрхлэгчийг үнэ төлбөргүй ажлын байраар хангаж, дэмжин ажиллаж байна. | 50% |
| 130 | 4.25.1 Дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг | - | Үйлдвэр эрхлэгчийг | 5 иргэний үйлдвэрлэ | Үйлдвэрлэл эрхлэгчдийн | Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2 дугаар байрны 1 давхарт байрлах 2 | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дэмжих төвийн дэргэдэх "Бойжуулах төв"-д өрхийн үйлдвэрлэл эрхлэгчийг хамруулж, дэмжин ажиллана. | | ажлын байраар хангасан тоо | лийг дэмжин ажилласан. | борлуулалт нэмэгдсэн байна. | өрөө 32м2 өрөөнд "Бойжуулах төв"-д 12 үйлдвэрлэл эрхлэгчийг үнэ төлбөргүй ажлын байраар хангаж, дэмжин ажиллаж байна.<br><br>2021 оны эхний хагас жилийн байдлаар 12 үйлдвэрлэл эрхлэгчид нийлбэр дүнгээр 9,8 сая төгрөгийн бараа, бүтээгдэхүүний "Хан-Уулд үйлдвэрлэв" борлуулалтын төв болон зах худалдааны төвөөр зарж борлуулсан байна. | |
| 131 | **Зорилт 4.26** Захын болон алслагдсан гэр хороолол, амралт зугаалгын бүс, иргэд олноор цуглардаг газруудад утасгүй интернэтийн сүлжээ суурилуулах ажлыг үргэлжлүүлнэ. /ДЗДҮАХ 3.2.4/ | - | Сүлжээ суурилуулсан эсэх, байршлын тоо | 16,13,12-р хороодын цэцэрлэгт хүрээлэнд суурилуулсан. | Утасгүй интернэтийн сүлжээ суурилуулах байршлын тоог нэмэгдүүлнэ. | Дүүргийн 2021 оны төсөвт суугаагүй тул тодотголд санал оруулахаар бэлтгэж байна. | 10% |
| 132 | 4.26.1 Утасгүй интернэтийн сүлжээ суурилуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна. | - | Байршуулсан сүлжээний тоо | 16,13,12-р хороодын цэцэрлэгт хүрээлэнд суурилуулсан. | Утасгүй интернэтийн сүлжээ суурилуулах байршлын тоог нэмэгдүүлнэ | 8 дугаар хорооны цэцэрлэгт хүрээлэн, 41 дүгээр сургуулийн цэцэрлэгт хүрээлэн 120-ын "Шинэ Хан-Уул" цэцэрлэгт хүрээлэн зэрэг газруудыг судалж байгаа бөгөөд 2021 оны төсөвт суугаагүй тул судлагдах түвшинд явж байгаа. Төсвийн тодотголд санал оруулахаар бэлтгэж байна. | 10% |
| 133 | **Зорилт 4.27** Дүүргийн иргэд болон гадаадад амьдарч байгаа иргэдэд зориулж төрийн үйлчилгээг хялбаршуулах, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор мобайл аппликейшныг хөгжүүлэн, цахимаар үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ. /ДЗДҮАХ 3.2.1/ | - | Мобайл аппликейшныг нэвтрүүлж, хөгжүүлсэн эсэх | - | Цахимаар авах үйлчилгээний тоо тодорхой хувиар нэмэгдсэн байна. | Мобайл аппликейшныг нэвтрүүлж эхэлсэн бөгөөд манайд байрлуулах сервер байгүй учир түр гүйцэтгэсэн компанийн сервер дээр үйл ажиллагаа нь явагдаж байна. | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 134 | 4.27.1 Мобайл аппликейшныг хөгжүүлэх техникийн даалгаврын дагуу хяналт тавьж ажиллана. | - | Техникийн даалгаврыг боловсруулан эсэх. | - | Техникийн даалгаврыг бүрэн хийж гүйцэтгэж, танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьсан байна. | Мобайл аппликейшныг нэвтрүүлж эхэлсэн бөгөөд манайд байрлуулах сервер байгүй учир түр гүйцэтгэсэн компанийн сервер дээр үйл ажиллагаа нь явагдаж байна. | 50% |
| 135 | **Зорилт 4.28** Дүүргээс аж ахуй нэгж байгууллагуудад үзүүлж буй төрийн үйлчилгээг үе шаттайгаар цахимжуулах ажлыг холбогдох төрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ. /ДЗДҮАХ 3.2.3/ | - | Цахим системд аж ахуй нэгж байгууллагуудыг бүрэн хамруулсан эсэх, Үйлчилгээний нэр төрөл, тоо | - | Цахимжуулсан төрийн үйлчилгээний нэр төрөл нэмэгдсэн байна. | Нийслэлийн мэдээллийн технологийн газартай хамтран худалдаа, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийг бүртгэлжүүлэхээр судалгаа, мэдээллийг шинэчлэн 1023 аж ахуйн нэгжийн мэдээлэл хүргүүлсэн. | 50% |
| 136 | 4.28.1 Дүүргийн худалдаа үйлчилгээний цэг салбарыг нэгдсэн цахим системд оруулж, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй түргэн шуурхай болгоно. | - | Цахим системд оруулсан аж ахуйн нэгж байгууллагын тоо | - | Цахим системд оруулсан аж ахуйн нэгж байгууллагын тоог нэмэгдүүлнэ. | Газар зүйн мэдээллийн систем Arcgis программд дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхэлж буй иргэн аж ахуйн нэгжийн хариуцсан орчны 50 метрийн зураглалыг оруулан Google earth программд хөрвүүлэн мэдээллийн сан үүсгэн ажиллаж байна. Тус программд нийт 200 гаруй иргэн, аж ахуйн нэгжийн мэдээллийг оруулаад байна. | 50% |
| 137 | **Зорилт 4.29** Төсвийн төлөвлөлт, зарцуулалтыг ил тод болгож, хариуцлагатай байдлыг дээшлүүлэхэд иргэд, олон нийт, татвар төлөгчдийн оролцоог хангана. /ДЗДҮАХ 4.4.1/ | - | Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, хувь, нээлттэй, ил тод мэдээлсэн эсэх | Төсвийн орлогын биелэлт 112,5 %, зарцуулалтыг үр дүнтэй, иргэдэд нээлттэй, ил тод мэдээлсэн. | Төсвийн орлогын биелэлт 80% -аас доошгүй байх, нээлттэй, ил тод мэдээлсэн байна. | 2021 оны эхний хагас жилийн орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 38,000,706,8 мянган төгрөг, 06 сарын 17-ны өдрийн байдлаар гүйцэтгэл 30,760,639.0 мянган төгрөг буюу 80,95 %-ийн биелэлттэй байна. Мэдээллийн ил тод байдлыг хангаж нийт 12 төрлийн мэдээг 1-5 дугаар саруудад Shilendans.gov.mn сайтад байршуулан иргэд олон нийтэд ил тод нээлттэй мэдээлэн ажиллалаа. | 50% |
| 138 | 4.29.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн орлого, | - | Төсвийн орлогын | Батлагдсан төсвийн | Батлагдсан төсвийн | Улс, нийслэл, орон нутгийн төсвийн орлогыг жилийн эхнээс жигд хангаж биелүүлэн ажиллах тухай дүүргийн Засаг даргын 2021 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зарлагын гүйцэтгэлд сар бүр дүн шинжилгээ хийж, Татварын хэлтэстэй тулган баталгаажуулж, жилийн эцсийн тооцоог нийлэх, төсвийн орлого давсан, тасарсан талаар мэдээлэх, төсвийн зарлагын хэмнэлт, хэтрэлтийг удирдлагад танилцуулах. | | гүйцэтгэл, хувь | хуваарийн дагуу төлөвлөгөө биелсэн. | хуваарийн дагуу төлөвлөгөө биелсэн байна. | оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/23 дугаар захирамжийн төслийг бэлтгэн батлуулж, холбогдох хэлтсүүдэд хүргүүлсэн. Энэхүү захирамжийн дагуу төлөвлөгөө тасарсан татварын орлогуудын талаар хийх ажил, анхаарах асуудлын талаар Татварын хэлтэстэй хамтран ажиллаж байна. Тухайлбал: Хог хаягдлын хураамжийн орлогын сар бүрийн гүйцэтгэлийг Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ, Хан-Уул Агро ОНӨААТҮГ, Хан-Эко тээвэр ОНӨААТҮГазартай гэрээний дагуу тооцоо нийлж сар бүрийн 03-ны дотор тогтмол ирүүлж хэвших, хамтран ажиллах талаар уулзалт зохион байгуулсан бөгөөд төсвийн орлого давсан, тасарсан, төсвийн зарлагын хэмнэлт хэтрэлтийн талаар удирдлагыг тухай бүрд мэдээллээр ханган ажилласан. | 50% |
| 139 | 4.29.2 Орон нутгийн 2022-2024 оны төсвийн хүрээний дунд хугацааны төлөвлөгөөний төслийг орон нутгийн төсөвт байгууллагуудаас гаргуулан хянаж боловсруулах, төсвийн төлөвлөлтийн шинэ программд нэгтгэн батлуулж, Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлж нэгтгүүлэх. | - | Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл тоо, чанараар | 2021-2023 оны төсвийн хүрээний дунд хугацааны төлөвлөгөө хуулийн хугацаанд нэгтгэгдсэн . | Хуулийн хугацаанд нийслэлийн СТСХ-т хүргүүлж, нэгтгүүлсэн байна. | Хугацаа болоогүй. | - |
| 140 | 4.29.3 Дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны төсвийн төслийг боловсруулж, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн барьж | - | Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл тоо, хуулийн хугацаа | Дүүргийн 2021 оны төсөв 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдөр | Хуульд заасан хугацаанд батлагдсан байна. | Хугацаа болоогүй. | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах. | | | батлагдсан | | | |
| 141 | 4.29.4 Төсвийн тодотгол хийх шаардлага, нөхцөл, хуулинд заасан үндэслэл үүссэн тухай бүр тодотголын саналыг боловсруулан хянуулж, ИТХурлаар хэлэлцүүлэн батлуулах. | - | Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл тоо, чанараар | Дүүргийн орон нутгийн төсөвт 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдөр өөрчлөлт оруулан батлагдсан | Хуульд заасан хугацаанд тодотгон батлагдсан байна. | Орон нутгийн 2020, 2021 оны 1 дүгээр улирлын төсвийн гүйцэтгэл, 2021 оны төсвийн тодотголын саналыг урьдчилсан байдлаар файл болон илтгэл хэлбэрээр боловсруулан, удирдлагад танилцуулсан. | 50% |
| 142 | 4.29.5 Орон нутгийн 2021 оны батлагдсан төсвийн орлого, зарлагын сар, улирлын хуваарийг төсөвт байгууллага, зардал бүрээр боловсруулж батлуулах, төлөвлөлтийн Фискал-5.5 системд байгууллага бүрээр шивж нэгтгэн бааз үүсгэж, төв төрийн санд илгээж, төсвийн сар, улирлын хуваарийг татуулж, үр дүнгээр нь санхүүжүүлэх, гүйцэтгэлд нь хяналт тавих. | - | Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл тоо, чанараар | 2020 онд батлагдсан төсвийн хуваарийн дагуу санхүүжилт олгогдсон, өр авлагагүй ажилласан. | Батлагдсан хуваарийн дагуу санхүүжилт олгогдсон, өр авлагагүй ажилласан байна. | 2021 оны дүүргийн орон нутгийн 33 байгууллага, хөтөлбөр, зардлын төсвийн сар, улирлын хуваарийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан төсвийн дагуу боловсруулж, Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 56,614.2 сая төгрөгийн батлагдсан төсвийг байгууллага тус бүрийн жилийн төлөвлөгөө, төсвийн сар, улирлын орлого, зарлагын хуваарийг төлөвлөлтийн Фискал-5.5 системд хийж батлуулан санхүүжилтийг олгуулан ажилласан. Эхний 6 сарын байдлаар 31,866.5 сая төгрөгийн төсвийн хуваарийг сар бүр хийж батлуулан санхүүжилтийг хугацаанд нь олгуулан ажилласан. Тайлант хугацаанд ИТХ, Татварын хэлтэс, ГБХЗХХ-ийн 1721.6 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн эрхийг нээж, зардлын данснуудад хуваарилав.<br>“Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн систем”-ийн сүлжээ буюу “Freebalance” программын журнал ваучераар орон нутгийн 12 байгууллага, Засаг даргын нөөц, ОНХО, 8 ОНӨААТҮГазар, ТШБ-ын тогтмол зардлын санхүүжилтэд нийт **24 587 185.7** мянган төгрөг, тусгай шилжүүлгийн 48 | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагад **31 556 542.2** мянган төгрөг нийт **56 143 727.9** мянган төгрөгийн зарлага, санхүүжилт олгон ажилласан. Нийслэлийн төсөвт **14 169 225.0** мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлэв. | |
| 143 | 4.2.6 Дүүргийн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайланг улирал, хагас, бүтэн жилээр үнэн зөв тайлагнасан эсэхийг хянан баталгаажуулж, нэгтгэн дээд шатны байгууллагад хуулийн хугацаанд хүргэх. | - | Дүүргийн төсвийн байгууллагуудын нэгдсэн тайланд нэгтгэгдсэн тоо | 195 байгууллагын 2019 оны жилийн эцэс, 2020 оны эхний хагас жилийн Төсвийн гүйцэтгэлийн тайлан тэнцлийг Сангийн Яамны нэгтгэлийн Э-тайланд 100% нэгтгэсэн. | Төсвийн тухай хуулийн хэрэгжилт хангагдана. | Дүүргийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэлд хамрагддаг төсөвт 77 байгууллагын 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн санхүүжилт, касс харилцахын нэгтгэл, нэмэлт санхүүжилтийн тооцоог тулган Сангийн Яамны нэгтгэлийн Э-тайланд байгууллага бүрээр тулган шалгаж, хүлээн авч баталгаажуулан Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс болон Нийслэлийн Аудитын байгууллагад хүргүүлэн амжилттай шалгагдаж, стандарт дүгнэлт авсан. | 50% |
| 144 | 4.29.7 Орон нутгийн хөгжлийн сан, дүүргийн төсвийн хөрөнгө, өвөлжилтийн бэлтгэл хангах зардал, төсөл хөтөлбөрөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулах гэрээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу | - | Байгуулсан гэрээний тоо, мөнгөн дүн | 2020 онд нийт 10,497.8 сая төгрөгийн гэрээ байгуулсан | Байгууллагын гэрээний хэрэгжилт хангагдана. | 2020 -2021 онд он дамжин хэрэгжиж буй Ахмадын сувилал барих ажлын гэрээний хугацаа сунгаж гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан баталгаажуулсан. Шууд гэрээний ажлын хэсгээс ирүүлсэн Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлгийн ажил хянагдаж гүйцэтгэгчээр “Хүрд” ХК шалгарч, гэрээ байгуулсан.<br>Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй нийтийн зориулалттай орон сууцны засвар, тохижилт, мөн түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй нийтийн эзэмшлийн тохижилт /ногоон байгууламж/ зэрэг төсөл арга хэмжээний 3 гэрээ байгуулсан байна. | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулж, хянан батлуулах. | | | | | Өвөлжилтийн бэлтгэл хангах зардлаас Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн төвийн байрны дээврийн засварын ажлын гэрээ байгуулагдсан. | |
| 145 | 4.29.8 Орон нутгийн хөгжлийн сан, дүүргийн төсвийн хөрөнгө, өвөлжилтийн бэлтгэл хангах зардал, төсөл хөтөлбөрөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу санхүүжүүлэх, хяналт тавих. | - | Санхүүжилт олгосон биелэлт тоо, мөнгөн дүн | 2020 онд гэрээний гүйцэтгэлээр 5,360.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. | Тайлант хугацаанд хийгдсэн гэрээний гүйцэтгэлээр санхүүжилт олгогдсон байна. | Орон нутгийн хөгжлийн сан, дүүргийн төсвийн хөрөнгө, өвөлжилтийн бэлтгэл хангах зардал, төсөл хөтөлбөрөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт 243 667,7 сая төгрөгийн гүйцэтгэлийг хянан санхүүжүүлсэн байна. Мөнх Чандмань элч ХХК Юубокүр ХХК-ийн барьцааг дүгнэн протокол үйлдэж, барьцааг чөлөөлөн олгосон | 50% |
| 146 | 4.29.9 Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системийн зардлын ваучерт шивсэн гүйлгээний бэлтгэн нийлүүлэгч байгууллагын дансны формат, хүлээн авсан огноо, төлбөрийн хэлбэр, Төсвийн Ерөнхийлөн захирагчийн харилцах дансыг зөв сонгосон эсэх, ерөнхий дэвтрийн дансанд өглөгийг хэрхэн үүсгэсэн эсэх, кодын блокийг зөв оруулсныг тулган шалгаж гүйлгээг эцсийн байдлаар баталгаажуулах. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, гүйлгээний тоо, мөнгөн дүн | 25,840 ширхэг 182 тэрбум 066,0 сая төгрөгийн гүйлгээг хийн 100% өр авлагагүй ажилласан. | Төрийн сангийн үйл ажиллагааны журам биелэгдэж, байгууллагын төлбөр тооцоо хэвийн хийгдэнэ. | Төсөвт байгууллагуудын баталгаат гарын үсгийг маягтын дагуу 11 Төсвийн шууд захирагч, 13 нягтлан бодогчоос журмын дагуу шинэчлэн авч, Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд бэлтгэн нийлүүлэгчээр 268 байгууллага болон хувь хүн бүртгэсэн. Харилцагч төсөвт байгууллагуудын дансны нэгдсэн жагсаалт гаргаж, төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтнүүдэд хуваарилан, 2021 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр батлан, 2021 оны 1 дүгээр сарын 04-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд 9,289 ширхэг 73,056,874,547.69 төгрөгийн төлбөр тооцоог гүйцэтгэн, тулган шалгаж эцсийн байдлаар баталгаажуулан ажилласан. 2021 оны эхний хагас жилд 83 ширхэг мемориалын баримтын үнэн зөв байдал бүрдлийг хянан тайлангуудыг бэлтгэж, архивын нэгж үүсгэсэн. | 50% |
| 147 | 4.29.10 Төсвийн байгууллагуудын | - | Үйл ажиллагааны | 2020 оны төсвийн | Мэдээнд цэвэрлэх | Дүүргийн төсвийн гүйцэтгэлийн мэдээнд орон нутгийн байгууллагууд 16, өрхийн эрүүл | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг тулган баталгаажуулж, хуулийн хугацаанд Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлэх, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган, шаардлагатай мэдээллүүдийг хуулийн хугацаанд нь shilendans.gov.mn сайтад байршуулах | | хэрэгжилтийн тоо, хувь | гүйцэтгэлийн нэгдсэн мэдээг хуулийн хугацаанд хүргүүлсэн. 195 байгууллага Shilendans.gov.mn сайтад 100% байршуулсан | бичилт хийгдэн, нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн мэдээг хуулийн хугацаанд хүргүүлсэн байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | мэндийн төв 16, улсын төсвийн цэцэрлэг 28, сургууль 19, хувийн сургууль 25, цэцэрлэг 98, нийт 202 байгууллагын мэдээ нэгтгэгдэн, улсын төсвийн цэцэрлэг, сургууль болон орон нутгийн байгууллагуудын 1-5 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг Сангийн яамны программтай тулган баталгаажуулан ажилласан. Улсын төсвийн цэцэрлэг, сургууль болон орон нутгийн байгууллагуудын дансанд нийгмийн даатгалын байгууллагаас орсон орлого, нэр данс зөрүү орлого, байгууллагын өөрийн орлого зэргийг 1-5 дугаар саруудад 175 удаагийн бичилтээр Сангийн яамны санхүүгийн удирдлагын системд нэг бүрчлэн шивж оруулан, орлого цэвэрлэх бичилт хийгдсэн байна. Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл гэсэн нийт 12 төрлийн мэдээг хуулийн хугацаанд нь shilendans.gov.mn сайтад мэдээлж ажилласан. | |
| 148 | 4.29.11 Аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд И-Баланс системд цахим хэлбэрээр хүлээн авч, хянан баталгаажуулах, бүртгэлийн алдааг залруулах, арга зүйгээр хангаж ажиллах, шинээр | - | Хууль, тогтоомжийн заалтыг хангасан байх, байгууллага, иргэний тоо, хувь | 2019 оны жилийн эцсийн байдлаар 10518 тайлан буюу 78%-ийг хүлээн авсан. 2020 оны | 11400 ААНБ-ын 2020 оны эцсийн тайлан баталгаажсан, 7200 ААНБ-ын хагас жилийн тайланг баталгаажуулсан, 50 ААНБ-ын тайлангийн | Нэгтгэлийн программд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан өгвөл зохих нийт **14208** аж ахуйн нэгж, байгууллагаас 11518 тайлан буюу 81,1%-ийг цахим системээр ирүүлсэн байна. Үүнээс 10425 байгууллага буюу 73,3%-ийг баталгаажуулж, 1101 байгууллагын алдаатай болон аудитын байгууллагын нэрийн баталгаажуулалт хийгдээгүй тайланг буцаасан. 1810 аж ахуйн | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулагдаж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад санхүү, бүртгэлийн талаар заавар зөвлөгөө өгөх. | | | хагас жилийн байдлаар 6493 тайлан буюу 51.1%-ийг хүлээн авсан. 2019 оны жилийн санхүүгийн тайлан хүлээн авалт 78%. | залруулга хийсэн, 1200 аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд арга зүйн зөвлөгөө өгсөн байна. | нэгж байгууллага, иргэдэд арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. | |
| 149 | **Зорилт 4.30** Дүүргийн орон нутгийн өмчийг бүртгэлжүүлэх, өмч ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. /ДЗДҮАХ 4.4.3/ | | Хагас жил, бүтэн жилээр хийгдэх тооллогын тоо, хувь | 2020 онд 2 удаа хийгдсэн. | Хагас жил болон жилийн эцэст өмч хөрөнгийн тооллого хийгдсэн байна. | Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн А/63 дугаар тушаалаар тооллогын комисс томилогдон дүүргийн өмчид байгаа хөрөнгийн ашиглалтад хяналт тавих хагас жилийн тооллого хийх ажил зохион байгуулагдан явагдаж байна. Хан Эко тээвэр ОНӨААТҮГ шинээр байгуулагдсантай холбоотой хог тээврийн авто машиныг балансаас балансад шилжүүлэх баримт бичгийг бүрдүүлэн Нийслэлийн өмчийн бодлого зохицуулалтын газар холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн шийдвэрлүүлэв. | 50% |
| 150 | 4.30.1 Дүүргийн өмчид байгаа хөрөнгийн ашиглалтад хагас болон бүтэн жилийн тооллого хийх ажлыг зохион байгуулах, тооллогын үр дүнд хяналт шинжилгээ хийж, хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн тоо, хувь | 10 байгууллагад ашиглагдаж буй 87 нэр төрлийн 1772 тоо ширхэг бүхий нийт 135 сая | Хуулийн хэрэгжилт бүрэн хангагдан, хугацаанд нь зохион байгуулсан байна. | Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн А/63 дугаар тушаалаар тооллогын комисс томилогдон дүүргийн өмчид байгаа хөрөнгийн ашиглалтад хяналт тавих хагас жилийн тооллого хийх ажил зохион байгуулагдан явагдаж байна. Тамгын газрын өмч хамгаалах байнгын зөвлөл нь дүүргийн ЗДТГ-ын даргын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/01 тоот тушаалаар нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж дүүргийн орон нутгийн өмчийг | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 999 мянга 161,74 төгрөгийн эд хөрөнгө хамрагдсан | | бүртгэлжүүлэх, өмч ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэн дүүргийн ЗДТГ-ын шинээр худалдаж авах болон балансаас балансад шилжүүлэх эд хөрөнгүүд, актлах суудлын авто машин, мөн Хан Эко тээвэр ОНӨААТҮГ шинээр байгуулагдсантай холбоотой хог тээврийн авто машиныг балансаас балансад шилжүүлэх баримт бичгийг бүрдүүлэн Нийслэлийн өмчийн бодлого зохицуулалтын газар холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн шийдвэрлүүлэв. | |
| 151 | 4.30.2 Орон нутгийн хөгжлийн сан, дүүргийн төсвийн хөрөнгө, өвөлжилтийн бэлтгэл хангах зардал, төсөл хөтөлбөрөөр бүрэн хэрэгжсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг данс бүртгэлд бүрэн тусгахад хяналт тавих. | - | Данс бүртгэлд бүртгэсэн байгууллагын тоо | Хэрэгжсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гэрээний гүйцэтгэлээр хөрөнгийг дансанд бүртгэсэн эсэхэд хяналт тавин ажилласан. | Хэрэгжсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гэрээний гүйцэтгэлээр хөрөнгийг дансанд бүртгэсэн байна. | Орон нутгийн хөгжлийн сан, дүүргийн төсвийн хөрөнгө, өвөлжилтийн бэлтгэл хангах зардал, төсөл хөтөлбөрөөр бүрэн хэрэгжсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг данс бүртгэлд бүрэн тусгахад хяналт тавих ажлын хүрээнд 6 сарын 15-ны өдрийн байдлаар нийт 4 байгууллагад төсвийн хөрөнгөөр худалдан авч буй хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж авах тухай албан бичгийг хүргүүлж, биелэлтийг авч ажилласан. | 50% |
| **ТАВ. ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, БУСАД ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ, БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| Зорилт 5.1 Төрийн үйлчилгээг иргэдэд ил тод, түргэн шуурхай хүргэнэ. | | | | | | | |
| 152 | 5.1.1 Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг хангаж, албан хаагчдын зэрэг дэвийг шинэчлэх, бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээ тайланг гаргах ажлыг зохион байгуулна. | - | Зэрэг дэв олгосон албан хаагчдын тоо, хүний нөөцийн системийн баяжуулалт | 16 албан хаагчдын зэрэг дэвийг шинэчлэн, 112 албан хаагчийн мэдээллийг | 5-аас доошгүй албан хаагчийн зэрэг дэвийг шинэчлэн, тухай бүр системийн баяжилтыг хийнэ. | Засаг даргын Тамгын газар, хороодын төрийн захиргааны албан хаагчдын зэрэг дэвийн нэмэгдлийг шинэчлэн олгох тухай саналыг Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04/86 дугаар албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлсэн. Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 04 дүгээр арын 20-ны өдрийн Б/122 дугаар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | системд оруулсан. | | тушаалаар 14 төрийн захиргааны албан хаагчдын зэрэг дэвийн нэмэгдлийг шинэчлэн олгосон. Төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээг тухай бүр шинэчлэн hr.csc.gov.mn цахим хуудаст оруулж байна. 2021 оны эхний хагас жилийн байдлаар 76 албан хаагчийн мэдээллийг шинэчлэн оруулсан. | |
| 153 | 5.1.2 Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр хөтөлбөр боловсруулж, ажлын гүйцэтгэл, тогтвор суурьшилтай ажилласан байдал, амьдралын нөхцөлийг үндэслэн нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх, буцалтгүй тусламж олгоно. | - | Нийгмийн баталгааг хангасан албан хаагчдын тоо | 22 албан хаагчдын нийгмийн баталгааг хангасан | 20-оос доошгүй албан хаагчид дэмжлэг үзүүлсэн байна. | Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/44 дүгээр тушаалаар "Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг батлуулсан. Мөн Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 21 дүгээр тогтоолоор "Хан-Уул дүүргийн албан хаагчдын Нийгмийн баталгааг хангах нийтлэг журам"-ыг батлуулсан. Ар гэрийн гачигдлын улмаас дэмжлэг хүссэн 1 албан хаагчид Дотоод журмын дагуу 10.000.000 төгрөгийн буцалтгүй тусламжийг олгосон. Нийгмийн баталгааг хангуулахаар дэмжлэг хүссэн албан хаагчдын өргөдлийг хүлээн авч, 2021 оны 07 дугаар сард ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. | 50% |
| 154 | 5.1.3 Засаг даргын Тамгын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоол, ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар, тайланг 7 дугаар хавсралтаар тус тус боловсруулж тайлагнана. | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүн, хувь | 100 зорилтын хүрээнд 143 арга хэмжээг төлөвлөн 88.7 хувийн биелэлттэй "B" үнэлгээтэй үнэлүүлсэн | Гүйцэтгэлийн тайланг нэгтгэн, үр дүнг үнэлж дүгнүүлнэ. | Төсвийн Шууд захирагчийн "Гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгах саналыг хэлтэс, тасгуудаас хүлээн авч нэгтгэн 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр батлуулсан.<br>Тус төлөвлөгөө нь нийт 6 хэсгээс бүрдэж байгаа бөгөөд нэгдүгээр хэсэг Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 17 зорилт, 21 арга хэмжээ, хоёрдугаар хэсэг Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээнд 5 зорилт, 5 арга хэмжээ, гуравдугаар хэсэг Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээнд 13 зорилт, 15 арга хэмжээ, | 50% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дөрөвдүгээр хэсэг Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилт арга хэмжээнд 30 зорилт, 44 арга хэмжээ, Төрийн албаны тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд 1 зорилт, 43 арга хэмжээ, Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд 1 зорилт, 16 арга хэмжээ, нийт 67 зорилт 211 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн эхний хагас жилийн байдлаар 55.2 хувьтай хэрэгжсэн. | |
| 155 | 5.1.4 Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны тайланг сар, хагас, бүтэн жилээр нэгтгэн боловсруулж батлуулан, НЗДТГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст тайлант хугацаанд хүргүүлнэ. | - | Тайлагнасан байдал, үр дүн | Холбогдох албан тушаалтанд тайлагнах, НЗДТГ-т тайлант хугацаанд хүргүүлсэн. | Үйл ажиллагаа ил тод, бодитой үр дүнд хүрч, холбогдох албан тушаалтанд тайлагнасан байна | Засаг даргын Тамгын газрын 2021 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайланг нийслэлийн Засаг даргын 2017 оны 335 дугаар захирамжийн хавсралтад заасан журмын дагуу нэгтгэн боловсруулж нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн. | 50% |
| 156 | 5.1.5 Засаг даргын Тамгын газар, хороодын албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, үр дүнг үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулна. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар, тоо чанар | ЗДТГ-ын 55 албан хаагчдын үр дүнг үнэлж дүгнэн холбогдох урамшууллыг олгосон. | Хэрэгжүүлэх ажлууд бодитой үр дүнд хүрэхүйц төлөвлөгдөн, бүрэн хангалттай үнэлэгдсэн байна. | Засгийн газрын 2020 оны 217, 218 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах хүрээнд албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлж дүгнэх “Үнэлгээний баг”-ийн бүрэлдэхүүнийг ЗДТГ-ын даргын 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/65 дугаар тушаалаар батлуулан, Засаг даргын Тамгын газрын 10 хэлтэс, тасаг, албадын 67, хороодын 51 нийт 118 албан хаагчийн 2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 7,8 дугаар хавсралтаар батлагдсан загвар, аргачлалын дагуу хүлээн авсан. Үүнээс албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгжилтийг хангах нийтлэг үүргээ хангалтгүй гүйцэтгэн, удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийг хангалтгүй биелүүлэн "Сануулах" сахилгын шийтгэл ногдуулсан 1 албан хаагч, шинээр томилогдсон 7, жирэмсний ээлжийн амралтаа авч орж ирсэн 2, нийт 10 албан хаагчид үр дүнгийн урамшууллыг олгоогүй. Бусад 108 албан хаагчдад Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн Б/173 дугаар тушаалаар урамшууллыг холбогдох журмын дагуу олгосон. | |
| 157 | 5.1.6 Засаг даргын Тамгын газрын тайлангийн хурлыг хагас, бүтэн жилээр зохион байгуулна. | - | Хурал зохион байгуулагдсан эсэх, ажлын үр дүн, тайлагналт | Ковид-19 цар тахлын улмаас хурлын арга хэмжээ зохион байгуулагдаагүй. | Төлөвлөсөн ажлууд бүрэн хангалттай хэрэгжин, бодит үр дүнд хүрч, тайлагнасан байна. | Цар тахлын улмаас 2021 оны эхний хагас жилийн тайлангийн хурлын арга хэмжээ цуцлагдсан боловч хэлтэс, албадын үйл ажиллагааны тайланг хүлээн авч танилцан үнэлэлт дүгнэлт өгч, зөвлөмж хүргүүлсэн. | 50% |
| 158 | 5.1.7 Засаг даргын Тамгын газрын даргын шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулж, өгөгдсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь тайлагнана. | - | Үүрэг даалгаврын биелэлт, хувь, хугацаандаа тайлагнасан эсэх | 12 удаа зохион байгуулж, 89 үүрэг даалгавар өгөгдөн 85.3 %-ийн биелэлттэй хэрэгжсэн. | Биелэлтийг тухай бүр холбогдох албан тушаалтанд танилцуулж, хугацаанд нь тайлагнана. | Засаг даргын Тамгын газрын даргын шуурхай зөвлөгөөнийг 2021 оны эхний хагас жилийн байдлаар 8 удаа зохион байгуулж, 80 үүрэг даалгавар өгөгдөн 90,3% хувьтай хэрэгжсэн | 50% |
| 159 | 5.1.8 Явуулын нэг цэгийн үйлчилгээг зохион байгуулна. | - | Зохион байгуулсан эсэх, үйлчилгээ үзүүлсэн иргэдийн тоо | 4,5,6,7,8, 9,10,12,13, 14,16,21 дүгээр хороодод зохион байгуулж, 9772 | Арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байна. | Хугацаа болоогүй | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | иргэнд үйлчилсэн. | | | |
| 160 | 5.1.9 Хууль тогтоомж, Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Нийслэлийн Иргэдийн 4.31.10 Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаас тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг нэгтгэн, хяналт шинжилгээ үнэлгээ хийлгэн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулан батлуулж, хугацаанд нь тайлагнах. | - | Хяналтад авсан тогтоол шийдвэрийн заалтын тоо, үр дүн, тайлан | 15 тогтоол шийдвэрийн 30 заалтын биелэлт 94.2%-тай хэрэгжсэн. | Улирал тутам тогтоол шийдвэрийн биелэлтийг нэгтгэн хугацаанд нь тайлагнана. | Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны эхний хагас жилийн байдлаар 7 тогтоол шийдвэрийн холбогдох 41 заалтуудыг хяналтад авч, биелэлтийг Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасаг болон Засаг даргын дэргэдэх 29 хэлтэс, албадаас авч нэгтгэн, батлуулж, 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 04/846 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. /Биелэлт-67.5%/ | 50% |
| 161 | 5.1.10 Нийслэл, дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь тайлагнах, дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнийг тухай бүр зохион байгуулах | - | Дүүргийн шуурхай зөвлөгөөн зохион байгуулсан тоо, үүрэг даалгаврын биелэлтийн хувь, хугацаандаа | Үүрэг даалгавар 83%-тай хэрэгжсэн. | Биелэлтийг тухай бүр холбогдох албан тушаалтанд танилцуулж, хугацаанд нь тайлагнасан байна. | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн 2021 оны эхний хагас жилийн байдлаар 23 удаа зохион байгуулагдан, нийт 173 үүрэг даалгавар өгөгдөж, 87.8%-тай хэрэгжсэн. Дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнийг журмын дагуу 3 удаа цахимаар зохион байгуулан нийт 35 үүрэг даалгавар өгөгдөж, 86.6%-тай хэрэгжсэн. | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тайлагнасан эсэх | | | | |
| 162 | 5.1.11 Дүүрэгт хэрэгжиж буй бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх | - | Хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тоо, үр дүн, тайлан | 5 төрлийн бодлогын баримт бичигт хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн. | Бодлогын баримт бичгүүдэд хугацаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн байна. | Бодлогын баримт бичгүүдэд хяналт шинжилгээ хийгдэж байна. | 20% |
| 163 | 5.1.12 Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод хяналтыг тавих замаар үүрэг хариуцлагыг дээшлүүлж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна. | - | Хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн тоо, тайлагналт | Хяналт-шинжилгээ үнэлгээг 2 удаа зохион байгуулж, үр дүнг тайлагнасан. | 2-оос доошгүй удаа хяналт-шинжилгээ үнэлгээ хийнэ. | Цар тахлын улмаас хяналт шалгалтын ажлыг эхний хагас жилийн байдлаар зохион байгуулаагүй бөгөөд хоёрдугаар хагас жилд хийхээр төлөвлөсөн. | - |
| 164 | 5.1.13 Хороодын хэсгийн ахлагч нарын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулна. | 5.0 | Зохион байгуулсан эсэх, үр дүн | Зөвлөлдөх уулзалтад 187 хэсгийн ахлагчийг хамруулсан. | Арга хэмжээг зохион байгуулж, холбогдох албан тушаалтанд тайлагнасан байна. | Хугацаа болоогүй. | - |
| 165 | 5.1.14 Хороодын Засаг дарга, Зохион байгуулагч, Хөгжлийн нийгмийн ажилтан нарын ажил мэргэжлийн ур чадварын тэмцээнийг зохион байгуулна. | 12.0 | Хамрагдсан хороодын тоо, албан хаагчдын тоо | Нийт 20 хорооны 67 албан хаагч хамрагдсан. | Албан хаагчдын мэдлэг, ур чадвар дээшилсэн байна. | Хугацаа болоогүй. | - |
| 166 | 5.1.15 Хороодын Засаг дарга нарын шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулж, өгөгдсөн үүрэг | - | Шуурхай зөвлөгөөн зохион байгуулсан тоо, үүрэг | 4 удаа зохион байгуулж, 20 үүрэг даалгавар | Биелэлтийг тухай бүр холбогдох албан тушаалтанд | Хороодын Засаг дарга нар дүүргийн Онцгой комисс болон дүүргийн Шуурхай штабаас зохион байгуулсан цахим хурлуудад тогтмол оролцож, холбогдох чиг үүргийн хүрээнд | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | даалгаврыг хугацаанд нь тайлагнана. | | даалгаврын биелэлтийн хувь, хугацаандаа тайлагнасан эсэх | өгөгдөн 90%-тай хэрэгжсэн. | танилцуулж, хугацаанд нь тайлагнана. | өгөгдсөн үүрэг даалгаврыг тухай бүр хэрэгжүүлэн ажилласан. | |
| 167 | 5.1.16 Дүүргийн Засаг дарга, хороодын Засаг дарга нартай батламж гэрээг байгуулах арга хэмжээг зохион байгуулна. | - | Батламж гэрээг байгуулсан эсэх | 21 хорооны Засаг даргатай батламж гэрээ байгуулсан | Батламж гэрээний хэрэгжилтийг хангасан байна. | Дүүргийн Засаг дарга 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн хороодын Засаг дарга нартай батламж гэрээ байгуулан ажиллаж байна. | 50% |
| 168 | 5.1.17 Иргэдийн эрэлт, хүсэлт, өргөдөл, гомдлыг ERP "Өргөдөл гомдлын нэгдсэн систем" болон бусад арга хэрэгслээр хүлээн авч, шийдвэрлэлтийн хариуг иргэнд шуурхай өгч ажиллана. | - | Дүүргийн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн индекс, шийдвэрлэлтийн дундаж хоногоор | 3233 өргөдөл, гомдол, санал хүсэлтийг 08 хоног, 22 цаг, 08 минутад шийдвэрлэсэн. | Нийслэлийн түвшингээс доош хугацаанд шийдвэрлэж, хариу өгсөн байна. | Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/186 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандсан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журмыг мөрдөж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх, шийдвэрлэлтийн дундаж хугацааг зорилтод түвшинд хүргэхээр зорин ажиллаж байна.<br>2021 оны хагас жилийн байдлаар дүүргийн хэмжээнд нийт 1237 өргөдөл ирснийг хуулийн хугацаанд 1161, хугацаа хэтрүүлэн 7 өргөдөл гомдол шийдвэрлэн 67 өргөдөл судлагдаж байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2021 оны тайлант хугацаанд 07 хоног 08 цаг 00 минут байна.<br>Үүнээс: Засаг даргын Тамгын газарт 373 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлснээс 346 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 4 өргөдлийг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэн 22 өргөдөл судлагдаж байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 07 хоног 1 цаг 52 минут байна | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
